

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 – 60
1.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	10 – 51
2.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	51 – 53
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/</i>	54 – 60

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 56.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Д.Жаргалсайхан.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэмүүлэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын Аудитын менежер Ю.Энхтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны референт Ц.Рэнцэнтогтох, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны референт Н.Монголмаа нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Батлут, Ж.Золжаргал, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, Г.Лувсанжамц, Б.Тулга, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэмүүлэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын Аудитын менежер Ю.Энхтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны референт Ц.Рэнцэнтогтох, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны референт Н.Монголмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр нь хэлэлцэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж дууслаа.

“Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, Д.Үүрийнтуяа, Д.Бум-Очир нар үг хэлэв.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга, П.Мөнхтулга нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 23 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 82.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
09 цаг 20 минут

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая.

Та бүхэнд ирц 52.2 хувьтайгаар хүрсэн байна.

Ирцийг танилцуулъя. С.Ганбаатар 1 дүгээр тойргоос ирсэн байна, Д.Батлут 4 дүгээр тойргоос ирсэн байна, Ц.Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна, Х.Жангабыл гишүүн 3 дугаар тойргоос ирсэн байна, Ж.Золжаргал гишүүн 9 дүгээр тойрог ирсэн байна, Л.Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна, Г.Очирбат гишүүн ирсэн байна, Б.Пунсалмаа гишүүн ирсэн байна, Д.Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Б.Тулга гишүүн ирсэн байна, 5 дугаар тойрог, Б.Уянга гишүүн ирсэн байна, Д.Бум-Очир гишүүн ирсэн байна.

Ингээд ирц 56.5 хувьтай. Хэлээгүй хүн байна уу? Д.Үүрийнтуяа гишүүн ирсэн байна. 4 дүгээр тойрог.

Ирц бүрдсэн учраас өнөөдрийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааныг эхлүүлснийг мэдэгдье.

Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх ирсэн тул хэлэлцэх асуудлуудаа танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанаар нэгдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Нэгдүгээр хэлэлцэх асуудал.

Хоёрдугаар хэлэлцэх асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Та бүхэнд танилцуулна. Хэлэлцэх асуудлын хоёрдугаарт байна.

Гуравдугаарт, “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. “Эрдэнэс Тавантолгой” компанийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх төслийг танилцуулна.

Ингээд гурван хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Л.Мөнхбаясгалан гишүүн. Л.Мөнхбаясгалан гишүүний микрофон.

Л.Мөнхбаясгалан: Сая 2 хоног иргэд гадаа төв талбай дээр утааны эсрэг, утааны хяналтын сонсголыг хийж өгөөч ээ гэсэн хүсэлтээ жагссан байгаа.

Манай Байнгын хороон дээр Тавантолгой түлш компанийн үйл ажиллагааг хянах ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийг яаралтай ажилд нь оруулж өгөөч ээ.

Дээрээс нь, бид 5 жил “Энержи Ресурс” гэдэг компанийн хаягдлаар түлш хийж Улаанбаатарчуудыг хордууллаа. Энэ хооронд ямар ч үр дүн гарсангүй. Улам л утаа өтгөрч, улам л хортой нь илэрхий болсон. Энэ түлш хортой гэдэг нь илэрхий болсон.

Гэтэл бид үүнийг огт тоохгүй суугаад байгаа байхгүй юу. Тавантолгой түлш.

Дээрээс нь, “Энержи ресурс”-ийн нийлүүлж байгаа хортой хаягдлыг яагаад Улаанбаатар хот бүтэн 5 жилийн турш түлж байгаа юм бэ. Тийм ээ. Энэ асуудлаар яаралтай хяналтын сонсгол хийх хэрэгтэй байна.

Дээрээс нь, татварын хөнгөлөлт эдэлдэг. Татварын хөнгөлөлт эдэлдэг ийм компани. Энэ тал дээр хянан шалгах ажлын хэсгийг яаралтай байгуулж өгөөч ээ гэдэг саналтай байна. Хэлэлцэх асуудалд үүнийг оруулж өгөөч ээ.

С.Ганбаатар: Тэгвэл өөр хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал байхгүй бол.

Саяын Л.Мөнхбаясгалан гишүүний саналыг яаралтай авч хэлэлцэх ёстой. Үнэхээр утаа хүндрээд маш хүнд байгаа.

Харин ч манайхаас Д.Энхтуяа гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бас урьдчилж гараад нэлээн идэвхтэй ажиллаж байгаа.

Ингээд шуурхайлуулаад энэ утааны асуудалтай холбогдуулаад яаралтай ажлын хэсгийнхээ дүгнэлтүүдийг Байнгын хороогоор хэлэлцэх асуудлаар ажлын хэсэгтэйгээ би хамтарч ажиллана. Энэ талаар ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа.

Мөн Б.Уянга гишүүнээр ахлуулсан Үйлдвэр, технологийн паркттай холбогдуулан ажлын хэсгүүд нэлээн эрчимтэй ажиллахаар бэлтгэл ажлаа хангаж байгаа.

Харин Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан бас хойшлуулах санал тавиад төсвийн дараа болъё гэж байгаа. Үүнийгээ бид яаравчлуулах шаардлагатай байгаа.

Ингээд хэлэлцэх асуудал. Саяын Л.Мөнхбаясгалан гишүүний гаргасан хэлэлцэх асуудлыг яаралтай ойрын хугацаанд оруулж Байнгын хороогоор хэлэлцэх болно.

Ингээд хэлэлцэх асуудлаар өөр санал байхгүй бол батлагдсанд тооцлоо.
/алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудлын нэгдээ орьё.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслүүд**

/Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би Та бүхэнд танилцуулъя.

Сангийн сайд Б.Жавхлан ирсэн байна. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэмүүлэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн

зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ж.Алтантуяа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Б.Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга ирсэн байна.

Ингээд Үндэсний аудитын газраас Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Ц.Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд. Ц.Туваан сайдыг дуудаарай.

Б.Жавхлан сайд танилцуулж байх үед орж ирсэн байх ёстой шүү. Гишүүд асуулт асууна шүү. Манайхан утасдаарай.

С.Жавхланбаатар Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ирсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд. Сайдыг дуудаарай. Одоо энэ дээр Аж үйлдвэрийн байнгын хороо гишүүдийг хүндэтгэж, сайд нар нь ирэх ёстой шүү. Асуулт асууна. Сангийн яам танилцуулга хийж байх хооронд ирсэн байх ёстой шүү.

3.Тулга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга. 3.Тулга сайд ирсэн байна.

Бүрэлдэхүүнийг Та бүхэнд танилцууллаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

5 номерын микрофоныг нээж өгье. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баярлалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хэлэлцэн баталсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 онд төсвийн төслийг шинэчлэн боловсруулж өргөн барьж байна.

Төсвийн төсөлд зардлыг бууруулах талаар дараах зарчим баримталлаа.

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн шүүх, прокурорын байгууллагууд болон хүний Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын урсгал зардал тус тус хэвээр үлдлээ.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь бууруулах чиглэл барилаа.

а/салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах;

б/соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдралд хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

в/эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагуудаас бусад бүх байгууллагын тэтгэвэр, шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх

шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техникийн хэрэгсэл, худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах.

г/дээр дурдсан 50-иас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт, эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгох дотаци, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг тусгана.

Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна.

Зарим эх засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойш хойшлуулна.

6.Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлууллаа.

7.Хавдар судлалын үндэсний төв 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт зарлагын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо.

Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3.3 хувийн ашигтай болохоор байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Үндэсний аудитын газрын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням Та бүхэнд танилцуулна.

3 номерын микрофоныг нээж өгье.

Я.Самбууням: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьсан байна.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага, цэвэр зээлийн дүнг 33 их наяд 470 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.2 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 3 их наяд 173.4 тэрбум төгрөгийн ашигтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 3.3 хувиар тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар төлөвлөжээ.

Тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг 2025 оны төсвийн төсөлд тусгахдаа дараах байдалтай тусгажээ.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын төсвийг 424.2 тэрбум буюу суурь тэнцлээс 70.1 тэрбум төгрөгөөр бууруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсвийг 412.8 буюу 342 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Зам тээврийн сайдын төсвийг 110.7 тэрбум буюу 1 их наяд 535.5 тэрбум төгрөгөөр бууруулж, Эрчим хүчний сайдын төсвийг 7.9 тэрбум төгрөгөөр бууруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийг 49.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэхэд дараах дүгнэлтийг өгсөн болно.

Нэгдүгээрт, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрт нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

Гуравдугаарт, цахим систем болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлгүйд тооцож, үр ашигтай төсөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

Дөрөвдүгээрт, төсвийн урсгал зарлагыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 оны төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

Тавдугаарт, Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

Зургадугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно.

Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газраас тогтооно гэж тус тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Баярлалаа.

Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Төсвийн ерөнхийлөн захирагч нар яаралтай ирээрэй.

Төрийн нарийн бичгийн даргууд нь ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хэн ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас. Бид хүлээнэ ээ.

Ж.Энхбаяр сайдыг, Ц.Туваан сайд ирж байгаа байх. Ирж байна уу? Энэ чинь бид өөрсдийгөө хүндлэх гээд байгаа юм биш шүү дээ. Монголын ард түмнийг л төлөөлж асуулт асуух гэж байгаа шүү дээ. Ард иргэдийнхээ төлөөллийн хувиас бид холбогдох яамдуудаас асуулт асууна.

Төсөв бол Монголын нийт ард түмэн, ажлын байр, орлого. Хамгийн чухал асуудал шүү дээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэн хариуцаж байгаа юм?

Эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн яамнаас Б.Жавхланбаатар Төрийн нарийн ирсэн байна.

Аж үйлдвэрлэгч нарыг хүндлэх байх. Бид хүлээнэ ээ.

Яамдуудад нь хэлээрэй, утсаар хэлээрэй. Ард түмэн даяараа л бид хүлээж байна шүү. Аж ахуй, аж үйлдвэрлэгч нар Монгол орны хамгийн чухал асуудал болчихсон байгаа шүү. Ажлын байр, орлого, аж үйлдвэрлэгч нар.

Бид асуултаа асуух гээд хүлээж байна. Энэ хооронд цаг ашиглаад асуулт асуух гишүүдийнхээ нэрсийг авъя.

Ингээд холбогдох яамд болон энэ асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Д.Энхтуяа гишүүнээр тасаллаа. Ж.Золжаргал гишүүн бас асуулт асуухаар өгсөн

юм байна шүү. Г.Лувсанжамц гишүүний нэрийг оруулъя. Ж.Золжаргал гишүүний нэрийг оруулъя.

Сангийн сайд Б.Жавхлан сайд ирсэн байна. Манай Б.Тулга сайд ирсэн байна.

Ингээд Ц.Туваан сайд Төрийн нарийн бичгийн дарга. Б.Жавхланбаатар даргыг явуулсан байгаа.

Дараагийн ээлжид сайд өөрөө ирж бас гишүүдэд хариулах ёстой шүү. Тэрийг хэлье. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд хаана явж байгаа юм бол. Ж.Энхбаяр сайд хаана яваа юм. Ойрхон явж байгаа гэсэн үү? Ямар ч байсан Төрийн нарийн ч гэсэн алга байна шүү. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас. Ц.Болорчулуун дарга орж ирсэн байна.

Дүрмээрээ сайдаас асуух ёстой байх аа. Ц.Болорчулуун дарга ирж байна уу? Замд явж байна уу? Бид хүлээнэ ээ.

Эрхэм гишүүдэд зүгээр энэ хооронд танилцуулахад төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйл дээр 71.3-д Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд, Байнгын дэд хорооны эрх дэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас гэж байгаа шүү.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар гэдэг бол сайд нар байгаа.

Асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж, үг хэлж болно гэж байгаа.

Ингээд төсвийн хоёрдугаар хэлэлцүүлгийн дэгийн тухай хуулиараа бид төсвийн ерөнхийлөн захирагч нараа хүлээж байна. Сүүлд ирцэд орсон гишүүд бас асуултад нэрээ өгнө гэвэл надад хэлээрэй. Б.Тулга сайд асуулт асууна. Нэрийг оруулъя.

Ингээд сайд нар орж ирж байна. Бид ингээд Засгийн газрын сайд нараа хүндэтгэлтэйгээр хүлээж, Улсын Их Хурлын гишүүд нэлээн хүлээж авч байна.

Ингээд Монгол Улсын гишүүд, яамдууд бүрэлдсэн учраас одоо асуултуудаа асууна.

Ингээд Б.Уянга гишүүнээр асуултаа эхэлье.

Б.Уянга: Өглөөний мэнд хүргэе.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гурван асуулт байна.

Хамгийн нэгдүгээрт болохоороо энэ бяслагийн үйлдвэртэй холбоотой асуултыг асууя.

Танилцуулгаас уншихад ер нь Хөвсгөл аймгийн сумдад бяслагийн үйлдвэрийн төслийг 2021 оноос авхуулаад “Бяслагийн үйлдвэр” гэж эхлүүлээд, дараа нь “Бяслаг төсөл” гээд дандаа Хөвсгөл аймгийг онцлоод авсан байдаг юм байна.

Тэгээд энэ аймаг сонголтыг нь хэрхэн хийсэн байдаг юм бол? Танай яамны эрхлэх ажил байх.

Тэгэхээр баригдсаных нь дараа орон нутгийн өмчид шилжүүлнэ гэж ойлгосон.

Тэгээд хэрвээ үнэхээр тийм орон нутгийн өмчид шилжүүлээд ашигтай байхаар байсан хувийн хэвшил нь өөрсдөө ороод хийчих байсан юм биш үү. Заавал төсвөөс, энэ төрөөс хийгээд ороод ажиллуулах нь ямар шаардлагатай вэ? Энэ яг ашигтай байна гэсэн тийм баталгаа байгаа юу?

Орон нутгийн өмчид шилжлээ гэж бодоход энэ нь хэрвээ ашиггүй ажиллаад байвал дараа нь хуульд ямар санкц суусан байдаг вэ? Энэ эхний асуулт.

Хоёрдугаарт нь, “Ургамал хамгааллын газар” гээд байгуулагдах гэж байгаа юм байна. Энэ онд 500 сая төгрөгийн төсөв тавигдсан байна.

Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр Ойн газар гээд байдаг. Ургамлуудыг хооронд нь өөрчлөөд байгуулж байгаа нь агентлаг байгуулаад, өөр өөр яамдын харьяанд оруулах нь хэр зөв зохистой вэ?

Яамд хоорондын уялдаа хэрхэн хангагдах вэ? Энэ 500 сая төгрөгийн төсөв 2024, 2025 онд тавигдахдаа ямар ямар ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа вэ? Яг тодорхой хариултуудаа л өгчихвөл болох гээд байна.

Гуравдугаарт нь, хувийн хэвшлийн байгууллагад олгодог дотаци өмнө нь орж ирсэн төсвөөс 554 тэрбум төгрөг байсан. Одоо бол энэ шинэ төсөв дээр 465 тэрбум төгрөг болж орж иржээ.

Энэ хувийн хэвшилд олгож байгаа урамшуулал гэж ойлгож байгаа. Тэгсэн хэрнээ өнөөдөр сүү болон махны үнэ Монгол Улсад маш их үнэтэй байгаад байдаг. Улам өссөөр байгаад байдаг.

Тэгэхээр дотаци нэмэр болохгүй байгаа юм биш үү? Бид яг юун дээр алдаад байгаа юм бол оо? Яг юуг цаашид хийх ёстой вэ? Ийм гурван асуулт байна.

С.Ганбаатар: Б.Уянга гишүүний асуултад Ж.Энхбаяр сайд хариулъя. 6 номерын микрофоныг нээж өгье.

Ж.Энхбаяр: Гишүүдээсээ уучлал хүсье ээ.

Та бүгдийн өглөөний мэндийг эрье.

Бяслэг Хөвсгөл аймгийн гишүүдийн санаачилгаар Улсын Их Хурал дээр нэмэлтээр орсон ийм төсөл байгаа юм байна лээ. Энэ 2023 оноос хэрэгжээд тэгээд 2025 он дуусахаар.

Энэ удаагийн төсөв дээр тавьсан үлдэгдэл бол энэ төслүүдийг гүйцээн дуусга гэдэг ийм маягаар тухайн орон нутгаас сонгогдсон гишүүдийн санаачилгаар хэрэгжиж байгаа төсөл.

Нөгөө талаар Хөвсгөл маань үхрийн гол цөм нутгийн нэг.

Тэгэхээр тухайн нутаг орон өөрийн хөгжилдөө, аялал жуулчлалын бодлогод энэ бяслагийн зах зээлээр Хөвсгөл аймаг төрөлжих нь зүйтэй гэж үзэж, орон нутаг дотроо шийдэл гаргаж Их Хурлын гишүүддээ хүсэлт тавиад, тэгээд тэр нь улмаар хэрэгжиж байгаа гэдэг ойлголттой явж ирсэн.

Тэгээд 2025 он гэхэд дуусна.

Тэгээд удахгүй Хөвсгөл аймгийн бүх сумд бяслэг үйлдвэрлэгч ийм жижиг үйлдвэртэй болоод бүтээгдэхүүнээ гаргах байх гэж хүлээлттэй байгаа.

Нийт салбарт таны ярьдаг урамшуулал гэж дурдагдлаа.

4 төрлийн том бодлого байгаа.

- ▶ “Цагаан алт”,
- ▶ “Хүнсний хувьсгал”,
- ▶ “Шинэ хоршоо”,
- ▶ “Атрын IV аян”.

Энэ туссан урамшуулал дотацын 463.6 тэрбум төгрөг бол аж ахуйн нэгжүүдэд очиж байгаа зээлийн хүүгийн хөнгөлөлтөд арилжааны банкуудад өгдөг санхүүжилт.

Нэг том бодлогын өөрчлөлт гарсан. Яам өөрөө мөнгө хуваадаг, бодлого гаргадаг, үйлдвэр барьдаг ийм зүйл үндсэндээ байхгүй болсон.

Улсын Их Хурлын гаргасан бодлого энэ бодлого, энэ 4 хөтөлбөр бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгатай, Улсын Их Хурлын бодлого болгож баталсан ийм 4-өөс 5 жилийн хугацаатай хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд байгаа.

Тэр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж дуусгахын тулд хувийн хэвшилд өгч байгаа санхүүжилт.

Үндсэндээ энэ 463.6 тэрбум төгрөг гэдэг маань бараг 2.5 их наяд төгрөгийн зээл болж хувийн аж ахуй, баялаг бүтээж байгаа, татвар төлж байгаа, ажлын байр бий болгож байгаа аж ахуйн нэгжүүдэд очиж байгаа.

Нөгөө талаар энэ 4 хөтөлбөр туссан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар маань Монгол Улсад ажиллах хүчний хоёрны нэгийг хангаж байгаа. 600 гаруй мянган хүн ажиллаж байгаа. Нийгмийн тогтвортой байдлыг гол хангаж нийгмийн баялгийг гол хуваарилалтыг тун тэгш эвтэйхэн хүргэж байгаа ийм салбар.

Монгол Улсын иргэд нутаг орондоо амгалан тайван, орлоготой, ажилтай байхад явж байгаа төрийн гол бодлого хэрэгжиж байгаа.

Хэрэгжээд хоёроос гурван болж байгаа. Үндсэндээ 2028 он гэхэд энэ бодлогууд хэрэгжиж үр дүнгээ гаргана. Үр дүн өндөр байгаа.

Зөвхөн “Хүнсний хувьсгал” гэхэд л өнгөрсөн хугацаанд бид ковидоос авсан сургамж дээр тулгуурлаад хүнсний үйлдвэрлэлүүдээ нэлээн сайн дэмжсэн. 24 шинэ үйлдвэр орж, 200 гаруй шинэ бүтээгдэхүүн эх орондоо үйлдвэрлэгдэж хэрэглэгчдийн гар дээр очсон.

Зөвхөн 1 их наяд төгрөгийн экспорт энэ салбарт гадна талдаа нэмэгдсэн байгаа. Экспортоддог болсон.

Импорт олон тэрбум байсан. 250.0 тэрбумаар Монгол Улсын хүнсний импорт багасаж байгаа буюу байнга өсөж байгаа буюу их өөдрөг яваа салбар болж байгаа юм.

“Цагаан алт” гэдэг хөтөлбөрийн хүрээнд энэ жилээс эхэлж байгаа. Ноос, ноолуур. Ноолуур дотроо хонины ноос, тэмээний хөөвөр.../минут дуусав/

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайдын микрофоныг нээж нэмэлт минут өгье.

Ж.Энхбаяр: Тэмээний ноос, сарлагийн хөөврөө, мөн мал ачаагаас гарч байгаа арьс шир, нэхийгээ боловсруулалтын түвшнийг нь дээшлүүлэх, улмаар экспортод чиглүүлэх тэр бодлогыг дэмжсэн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл авсан аж ахуйн нэгжүүдийг энэ хүүгийн бодлогоор урамшуулж байгаа ийм л бодлого байгаа.

“Хоршоо хөдөлгөөн”. Монгол Улсын хэмжээнд байгаа нийт 300 гаруй мянган малчин өрх байна. Эднийгээ аж ахуйн зохион байгуулалтад оруулж, энэ үйлдвэрлэлийнхээ түүхий эдийг бэлтгэдэг гол суурь хөдөлмөрөөрөө хоршдог. Нөгөө талаараа байгаль, цаг уурын эрсдэлд эрс өртөмтгий болоод байгаа нүүдлийн мал аж ахуйгаа тэр эрсдэлээс хамгаалах тэр тэжээлээ тарьдаг, хамтран хөтөлбөрөөр хоршдог. Ингээд үйлдвэрлэлийн гол түүхий эдийг хариуцлагатайгаар биелүүлдэг, нийлүүлдэг нэг ийм хөдөлмөрийн зохион байгуулалтад оруулж байгаа. Тэр бодлогыг дэмжсэн ийм хөтөлбөр “Шинэ хоршоо” хөтөлбөр.

Мөн адилхан дотаци буюу зээлийн урамшуулал. Тэр хөрөнгө.../минут дуусав/

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайд товчхон базаад хариулахыг бодъё.

Ингээд тодруулах уу? Ургамал хамгаалалттай холбоотой асуултад та хариулна уу. Ж.Энхбаяр сайдын микрофоныг нээж өгье.

Ж.Энхбаяр: Энэ ургамал хамгааллын асуудал ойн асуудлаас маш тустай. Үндсэндээ бэлчээр болон энэ хүнсний асуудлыг дэлхийн хэмжээнд дэлхийн нийт Дэлхийн худалдааны байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллага, ер нь дэлхий дахинд хүнсний бодлогыг гол хэрэгжүүлдэг байгууллага нь энэ ургамал хамгааллын байгууллагууд байдаг.

Энэ байгууллагууд хоорондоо нөгөө Мал эмнэлгийн ерөнхий газар гэж мал эмнэлгийн байгууллагууд шиг харилцан гэрээ хэлэлцээр, аюулгүй байдлын протокол юмаа хийж зохицож байж дэлхий дээр энэ хоол, хүнсний худалдаа, импорт, экспортын ажиллагаа явагддаг. Харамсалтай нь манайх энэ бүтцээ байхгүй болгочихсон байсан.

Ингээд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцын дагуу энэ бүтцийг заавал бий болгож байж Монгол Улс энэ ургамлын чиглэлийн түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, олон улсын худалдаанд оролцох ийм бололцоо нөхцөл байдал үүсэж байгаа.

С.Ганбаатар: Б.Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Ж.Энхбаяр сайд ээ, ерөнхийд нь ойлгоод байгаа юм аа.

Мэдээж төрийн албанд ажиллаж байгаа мундаг мэргэжилтнүүд, газрынхан хоорондоо ярьж ярьж байгаад энэ хөтөлбөрүүдийг гаргасан байх.

Тэгээд яах вэ, зүгээр яг оновчтой хариултыг арай сонсохгүй л байна л даа. Жишээ нь, орон нутгийн өмчид бяслагийн үйлдвэрүүд шилжээд дараа нь яах юм? Ашиггүй байвал тэгээд дараа нь яах вэ? Энэ мэт дээр хариултуудыг.

Ер нь Их Хурлын хуульд заасны дагуу яг танай яам руу хаяглаад яг энэ асуултуудыг явуулчихъя даа. Тэгээд 2 хоногийн дотор эргээгээд яг оновчтой хариулаад өгвөл тэр их хэрэгтэй болох байх.

Тэгээд ийм байдлаар л шийдсэн нь зүгээр юм болов уу даа. дарга аа.

С.Ганбаатар: Б.Уянга гишүүн санал хэллээ. Та нар тодорхой хугацаанд хариугаа өгнө шүү.

Ингээд Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Өглөөний мэнд хүргэе.

Би өнгөрсөн чуулган дээр нэг асуудлыг асууж учрыг нь олчих гээд оролдоод байгаа юм л даа.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дээр байгаа. Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гэж яг юуг хэлээд байгаа юм гээд.

Тэгээд тэрний тухай мэдээллийг хайгаад ерөөсөө би олж авч чадахгүй байгаа байхгүй юу. Жишээлбэл, ийм ийм элементийг эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гэнэ гээд нэрлэсэн зүйл ерөөсөө алга. Тоймлосон. Ашигт малтмалын тухай хуулийн 47-г бариад л ерөөсөө.

Тэгэнгүүтээ АМНАТ тогтоодог асуудлууд гарч ирээд байгаа юм. Тодорхой шийдэл байхгүй гэсэн үг.

Тэгээд тэр нь болохоор манай Эрдэнэт үйлдвэр дээр тухайлах юм бол эдийн засгийнх нь нөхцөл байдалд нөлөөлөөд байгаа байхгүй юу. АМНАТ-ыг 20 хувиар авдаг.

Дээрээс нь, эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гээд тодорхойлж байгаад тэр зэс молибдены баяжмал дотор байгаа хар тугалга, цайр гэх мэтчилний элементүүдээс АМНАТ тооцож аваад байгаа юм.

Гэтэл яг үнэндээ зэсийн, молибдены баяжмалыг боловсруулахдаа тэр дагалдах гэж байгаа элементүүдийг салгахын тулд үйлдвэр өөрөө нэмэлт зардал гаргадаг тодорхой хэмжээтэй байдаг. Тухайлах юм тэр зэс, молибдены

баяжмалыг худалдан авч байгаа хүмүүс нь тодорхой хэмжээтэй байхыг зөвшөөрч, тэр хэмжээнээс илүү гарах юм торгууль тавьдаг бүр.

Ийм нөхцөл байдалд байгаад байхад яагаад үүнийг эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гэж нэрлээд, дээрээс нь давхар давхар АМНАТ-аар дарамтлаад энэ үйлдвэрийг хүнд байдалд оруулаад байгаа юм бэ?

Шүүх дээр энэ асуудал нь уг нь Эрдэнэт үйлдвэрийн талд гарсан л юм байна лээ л дээ.

Тэгээд л төрийн үйлдвэр учраас та нар төртэйгөө маргалдлаа, шүүхээр шийдвэр гаргуулж байна гээд ингээд асуудалд ханддаг. Энэ байдлаа хэзээ болих юм бэ.

Үүний чинь цаана юу бий болоод байгаа вэ гэхээр Эрдэнэт үйлдвэрийн 7 мянган ажилчдын асуудал, эрх ашиг зөрчигдөөд байгаа байхгүй юу. Дэлхийн жишиг үйлдвэр гэсэн мөртлөө дэлхийн жишиг цалин байхгүй, тэгээд техник, тоног төхөөрөмжийнх нь асуудал хүнд байгаа шүү дээ.

Оюу Толгойгоос, Тавантолгойгоос Белаз авчирч ашигласан. Түрээсэлж бүр. Хувийн хэвшлээс, уул уурхайгаас. Өөрсдөө техник, тоног төхөөрөмжийнхөө шинэчлэлийг хийж чадахгүй нөхцөл байдалд оччихоод байна.

Дээрээс нь, 30 гаруй тэрбум төгрөгөөр битгий дарамтлаад байгаач дээ. Асуудал нь тодорхой биш байхад, тэгээд түүнийгээ хуульчлаад, тэгээд баахан төлбөр нэхээд байх юм. Үүнийгээ хэрхэн яаж шийдэх юм бэ? Нөхөд өө. Энэ дээр нэг хариулт өгөөч.

С.Ганбаатар: Д.Батлут гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон дээр Б.Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулна.

Б.Жавхланбаатар: Гишүүний асуултад хариулъя.

Зөвхөн зэс дээр биш. Ер нь манай ашигт малтмалууд дээр дагалдах буюу эдийн засгийн эргэлтэд орж байгаа бага агуулгатай хүдрүүдийн асуудал үүсэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яаман дээр боловсруулаад явж байна. Ажлын хэсэг гарсан.

Улсын Их Хурал дээр Н.Наранбаатар гишүүнээр ахлуулсан бас ажлын хэсэгтэй. Яг энэ асуудлаар бас мэдээлэл солилцоод явж байгаа юм.

Тэгэхээр хуульдаа өөрчлөлт оруулж л үүнийг шийднэ гэсэн ийм гарц байгаа гэж харж байгаа.

С.Ганбаатар: Асуултад их тодорхой хариулъя. Хэлэлцэж байгаа л гэж л хариулчих шиг болох юм. Д.Батлут гишүүн тодруулах юм уу? Д.Батлут гишүүний микрофоныг нээж өгье.

Д.Батлут: Яах вэ, төсөв бүхэлдээ ингээд батлагдаад явчих байх.

Тэгээд энэ дотор чинь бас нэг нөлөөлөөд байгаа орон зай, тодорхой асуудлуудаар л гишүүд тал талын өнцгийг барьж асуугаад байгаа нь энэ шүү дээ.

Тэгээд ингээд асуунгуут тодорхой хариулт байхгүй. Хууль нь бөөрөнхий, тодорхой бус. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийг л барьсан гэж байгаа. Тэр нь тэгээд эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах элемент гээд. Тэгээд тэр нь юу байх юм гэхээр байхгүй. Зөвхөн энэ бол нэг жишээ байгаа юм.

Тэгэхээр үүн шиг маш олон зүйлүүд энэ хуулиудад байна.

Тэгээд өөрчлөх гээд байгаа л гэж байгаа юм л даа. Наад асуудал чинь үгүй мөн хол явна даа. Би зүгээр даапаалж хэлж байгаа шүү. Хол явна гэдгийг нь даапаалж хэлж байгаа юм.

Тэр хуулийн ажлын хэсэг ажиллаж л байгаа. Ажиллах эрмэлзэл дүүрэн байна. Олон асуудлуудыг цэгцлэх шаардлага байгаа л даа.

Тэгээд та бүхэн нэг тодорхой хариулт өгөөд ингэнэ тэгнэ гээд шийдчихгүй юу.

С.Ганбаатар: Б.Жавхлан сайд хариулъя. 5 дугаар номерын микрофоныг нээж өгье.

Б.Жавхлан: Д.Батлут гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ дээр хуулийг яаж ойлгох вэ, яаж хэрэглэх вэ гээд, ямар асуудал дээр маргаан тойрч үүсээд байна вэ гээд. Ялангуяа Оюу Толгойн төслийн хэрэгжилттэй холбоотой татварын маргаантай арбитрын асуудал байгаа юм.

Энэ дээрээс нэг ийм ойлголт гарчхаад байгаа юм. Өөр бас жижиг. Жижиг юу байх вэ. Бусад аж ахуй нэгжүүд дээр ч гэсэн ижил төстэй маргаанууд гараад байгаа юм.

Эдийн засгийн ач холбогдолтой, ач холбогдолгүй гэдэг тийм ашигт малтмал гэдэг ойлголт нэг үг үсэг, цэг ч байхгүй. Хууль дээр ээ.

Ашигт малтмалын хуулиар энэ АМНАТ бол бас яг шууд татвар биш шүү дээ. Энэ бол төлбөр. Ашигтай ч ажиллаж байсан, ашиггүй ч ажиллаж байсан төлөх ёстой төлбөр байгаа юм.

Тийм учраас үүнийг цуглуулж хураах нь Монгол Улсын татварын албаны үүрэг. Хуульд заасныгаа л хэрэгжүүлж байгаа асуудал.

С.Ганбаатар: Б.Жавхлан сайдад нэмэлт нэг минут өгье.

Б.Жавхлан: Одоо харин Ашигт малтмалын хууль дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж явж байгаа.

Тэр дээр саяын Д.Батлут гишүүний хэлээд байгаа тэр пеналти буюу татвараас чөлөөлөгдөх болон АМНАТ-аас чөлөөлөгдөх боломжтой дагавар гэх үү, дайвар гэх үү, дагасан жижиг элементүүд дээр чөлөөлөгдөнө өө ч гэдэг юм уу хуульд нь маш тодорхой оруулчих юм бол татварын алба үүний дагуу л ажиллаад явах байгаа юм. Тэр хуульдаа л их нарийн үүнийг нь заагаад маш тодорхой болгочихвол би болохоор л юм шиг харагдаад байгаа юм даа. Тийм.

С.Ганбаатар: Д.Батлут гишүүн тодруулъя.

Д.Батлут: Тэгээд хуульд ер нь ингэнэ тэгнэ гээд тодорхой заагаагүй байхгүй юу.

Тэгээд тодорхой заагаагүй болохоор Засгийн газар өөрөө давуу эрх эдэлчхэж байгаа юм уу? Ийм байж болохгүй биз дээ.

Тэгээд л нэг болж бүтэж байгаа нийгмийн сайн сайхны төлөө маш том хөрөнгө оруулалтуудыг хийдэг нэг үйлдвэрээ өөрсдөө ингээд л тал талаас нь хэмлээд байж болдог юм уу?

Энэ чинь өөрөө тодорхой биш байгаа юм. Тодорхой биш болохоор Засгийн газар өөрөө давуу эрх эдэлж байгаа юм уу? Энэ байдал чинь шүүх дээр эсрэг талдаа гарчихсан шүү дээ. Эрдэнэт үйлдвэрийн талд шийдвэр нь гарсан шүү дээ.

Тэгээд энэ байдлаа больчих ёстой байхгүй юу. Тодорхой биш байгаа юм бол үүнийгээ больчих л хэрэгтэй гэж хэлэх гээд байгаа юм.

С.Ганбаатар: Санал хэллээ. Ж.Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Баярлалаа. Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар 4.9 тэрбум төгрөг төлөвлөсөн юм байна. Буурч орж ирээд.

Тэгээд энэ сангийн зээлийн хэдэн хувь нь нөгөө муу ангилалд орсон байгаа бол. Үргэлжлүүлээд хэрэгцээ шаардлага нь байгаа учраас явахаар тусгагдсан байх.

Тэгэхээр 2025 оны олгох зээлүүдийн, нөгөө чанаргүй зээлийн хэмжээг бууруулахад яаж анхаарах вэ гэдэг асуулт байна.

Хоёрт нь, Зээлийн батлан даалтын сан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 50 тэрбумаас 45 болоод буурч орж иржээ.

Тэгээд Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгийн эх үүсвэр нь яг энд бол 100 хувь төсөв л байна л даа. Төсөв гэж байдаг уу? Засгийн газрын тусгай сангийн хууль дээрээс олсонгүй.

Тэгэхээр журмаар зохицуулагддаг юм шиг байна. Тэгээд энэ талаар мэдээлэл өгөөч гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яамны удирдлагаас хүсмээр байна.

Хоёр дахь нэг асуулт нь болохоор Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын тайланд шуурхай хяналт хийж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ гэсэн байгаа юм.

Шуурхай хяналт гэдэг ямар хяналт вэ? Холбогдох арга хэмжээ нь ямар арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа юм бол гээд ийм асуулт байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Ж.Золжаргал гишүүн маш тодорхой, цаг хугацаатай, эзэн биетэй нь хариулаач л гэж байх шиг байна. Аариулт өгье. Сангийн сайд Б.Жавхлан 5 номерын микрофоныг нээж өгье.

Б.Жавхлан: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгийн эх үүсвэр ер нь 100 хувь гэж ойлгож болно доо. Төсвөөс явдаг.

Яах вэ ангиллаар нь харах юм бол Азийн хөгжлийн банкны зээл, тусламжаар бас дүрмийн санг нь зузаатгасан байгаа.

Эрэлт хэрэгцээний хувьд хязгааргүй.

Тэгэхдээ жижиг, дунд үйлдвэрлэлийнхээ бодлогыг дагаад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам руу Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээ маань өөрөө тэр салбар луугаа чиглэдэг учраас энэ яаманд харьяалагддаг байгаа.

Д.Батлут гишүүний асуултад нэмж хариулахад энэ Засгийн газар давуу эрх гэж бас хэлж болохгүй юм. Энэ чинь ард түний өмнөөс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нь хурааж байгаа учраас бидний л ажил байгаа юм. Ямар юмных нь өрсөлдөөн, давуу тал байх вэ дээ.

Тэгээд тэр шүүхийн шийдвэр дээр тооцооллын зөрүү байна гэсэн болохоос биш дагалдах элементээс АМНАТ авч болохгүй гэдэг утгатай тийм шүүхийн шийдвэр гараагүй байгаа.

Өөрөөр хэлбэл хуулийг юу гэдэг юм аль нэг тийш нь тавиад тайлбарлачихсан зүйл байхгүй.

Ер нь ойлгомжтой. Эдийн засгийн ач холбогдолтой, ач холбогдол гэдэг ямар ч тийм ашигт малтмал байхгүй. Ашигт малтмал мөн л бол бүгдээс нь АМНАТ авах ёстой гэдэг л ийм л хуультай. Одоогоор тэр хуулиа хэрэгжүүлээд л явж байгаа.

Харин цаашдаа Ашигт малтмалын хууль дээр тэр финалти гэдэг ойлголтыг оруулах нь зүйтэй.

Түүн дээр Засгийн газар, яам нь ч гэсэн дэмжиж байгаа.

С.Ганбаатар: Б.Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга хариулна. 4 дүгээр номерын микрофон дээр хариулт өгье.

Б.Жавхланбаатар: Ж.Золжаргал гишүүний асуултад нэмж хариулъя.

Хувийн хөрөнгөөр хийсэн геологид хяна хяналт тавина гэдэг маань манай яаман дээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл ажилладаг.

Өөрөөр хэлбэл хувийн хөрөнгөөр геологи, хайгуул хийгээд, нөөцөө тогтоолгохдоо энэ зөвлөлөөр орж нөөцөө зөв тогтоосон уу, үгүй юу гэдгээ хянуулдаг юм. Үүнийг л хэлээд байгаа юм. Баярлалаа.

С.Ганбаатар: Ж.Золжаргал гишүүн асуултаа тодруулъя.

Ж.Золжаргал: Геологи хайгуул, нөөцийн юун дээр нөгөө хийгддэг ажил нь л хийгдэж байгаа юм байна гэж ойлголоо. Энэ дээр тусгайлаад биччихсэн болохоор лавлаж асуусан юм.

Сангийн яамнаас нөгөө ЖДҮ сангийн зээлийн чанарын талаар асуусан. Тэр дээр хариулт өгнө үү гэж хүсмээр байна. Хэдэн хувь нь муу зээлийн ангилалтай байгаа бол. 2025 онд зээлийн чанарын ангиллын сайжруулахын тулд ямар арга хэмжээ авах вэ гээд.

Хоёрдугаарт нь, нөгөө түрүүчийн асуусан Батлан даалтын сангийн 2019 оны Санхүүгийн зохицуулах хорооны 46 дугаар тогтоолоор батлагдсан журам байдаг юм шиг байна. Энэ журам л байх л даа. Тийм ээ.

Тэгээд үүний 2.29 дээр нь сан өөрийн нөөцийн сантай байх бөгөөд нөөц санг тайлант жилийн цэвэр дүнгийн 50-иас доошгүй хувиар байгуулж, батлан даалтын үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулна гээд.

Тэгээд энэ одоо жишээ нь жилийн 50 тэрбумын төсөвтэй бол 25 тэрбумын нөөцийн сантай байх ёстой гэсэн үг үү? Ийм нөөцийн сан нь байдаг юм болов уу? Ийм асуулт байна.

С.Ганбаатар: 6 дугаар номерын микрофон дээр Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: 2009 оноос анх Монгол Улс жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмжих ёстой гэдэг ийм бодлого гаргаж, зээл олгож эхэлсэн байна.

Нийтдээ 1.1 их наяд төгрөгийн зээлийг нь 25 жилийн хугацаанд олгосон байна. Энэ зээлийг олгохдоо

- улсын төсөв,
- Хөгжлийн банкны бонд,
- Засгийн газрын бонд,
- гадаад зээл гээд 4 эх үүсвэрээс мөнгө бүрдүүлж олгосон байна.

Өнөөгийн байдлаар бусдад төлөх өр төлбөрийг энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар 2000 онд “сан” байсныг жижиг, “дунд үйлдвэрлэлийн агентлаг” болгож чиг үүргийг нь өөрчилсөн.

Ингээд бусдад төлөх өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан байна. Өөрийн энэ зээлийн эргэлтийн эх үүсвэрийн үлдэгдэл гээд 200 гаруй тэрбум төгрөгийн үлдэгдэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Одоо жил тутам нөгөө эргэн төлөлтөөсөө буцаан.../минут дуусав/

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайдад нэмэлт минут өгье.

Ж.Энхбаяр: Нийт энэ нийт 8947 төсөл, аж ахуйн нэгж, иргэдэд зээл, арилжааны банкаар дамжуулан нийт 7146 төсөлд зээл олгож, нийт төслийн 80 хувь арилжааны банкаар дамжиж явсан байна.

Нэлээдгүй тооны зээл чанаргүй болсон байдаг. Оүнийг барагдуулах энэ тусгай активын газар байгуулаад зээлийн ажлыг нэлээн хөөцөлдүүлээд барагдуулалт нэлээн өндөр дүнтэй яваа. Хууль хяналтын байгууллагуудтай нэлээн сайн хамтарч ажилласан.

Сүүлийн 2 жил гэхэд Авлигатай тэмцэх газар, ил тод байдал, цахимжуулалт, үйл ажиллагааны чиглэлээр хамгийн тэргүүлж байгаа 2 төрийн байгууллагын 1, 2 жил дараалан шалгарсан. Юмнууд нь нэлээн цэгцэрчихсэн. Үндсэндээ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэл дээр зах зээл нээх, гадаад дотоод сурталчлах, хууль эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох зэрэг үндсэндээ төрийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Та та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Сангийн сайдаас нэг асуулт байна. Хөдөө аж ахуйн сайдаас бас нэг асуулт байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал орж ирж байгаа. Өнөөдөр Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр яг энэ хуулийн төслийг хэлэлцэхгүй гэж байгаа.

Тэгэхдээ үүнтэй холбоотойгоор тэр аудит хийх асуудал дээр аудитыг сонгох хуулийн этгээдийг сонгох тухай асуудал дээр Засгийн газарт яагаад эрх олгож орж ирсэн юм бол оо. Төрийн өмчийн компаниудын хувьд, оролцоотой ком аж аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ аудитын асуудлууд тусгай зохицуулсан хуулийн заалтууд байгаа гэж ойлгогдох юм. Нэгдүгээрт.

Хоёрт нь, Хөдөө аж ахуйн сайдаас асуух асуулт болохоор Евро-Азийн эдийн засгийн худалдааны гэрээ байгуулах тухай асуудал яригдаад байна.

Тэгээд энэ гэрээнд орох гэж байгаа хөдөө аж ахуйн төрлийн хөдөө аж ахуйтай холбоотой хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бүгд энэ гэрээнд тусаж байгаа юм байна. Тэр төсөл дээр нь явж байгаа юм байна. Бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, улаан буудай, төмс, өндөг, хүнсний ногоо, архи, пиво, ундаа гэх мэтчилэн.

Тэгээд үндсэндээ энэ гэрээнд яг энэ байгаа чигээрээ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд ороод энэ гэрээ зурагдах юм бол хөдөө аж ахуйн энэ үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд үндсэндээ үүд хаалгаа барих хэмжээнд хүрэх эрсдэл байна л даа. Импортын татваргүй бараа орж ирэх юм байна лээ шүү дээ. Гэрээ зурагдчихвал.

Тэгэхээр таны энэ нөгөө хүнсний хувьсгалтай холбоотойгоор 24 шинэ үйлдвэр байгуулагдаад, 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд, экспорт 1 их наядаар нэмэгдээд, 250 тэрбум төгрөгийн импортыг орлох бараа, бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэсэн байна гээд байдаг. Энэ үр дүн маань юу болох юм бэ?

Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолоор бид гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүнийг ирэх 5 жилд дотооддоо үйлдвэрлэнэ гэж заагаад, энэ 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэлд зориулж 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийг ирэх 5 жилд хийхээр төлөвлөсөн шүү дээ.

Үүнээс 833 орчим тэрбум төгрөгийн зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг нь гарчихсан байж байдаг.

Тэгээд энэ зээл авсан үйлдвэрүүд чинь ер нь тэгээд үүд хаалгаа бариад зээлээ төлж чадахгүй хэмжээнд очих юм биш үү. Энэ асуудал дээр Хөдөө аж ахуйн сайдын хувьд ер нь ямар байр суурьтай байгаа юм бол?

Сангийн сайд Засгийн газрын гол асуудлыг хариуцаж байгаа сайдын хувьд бас байр сууриа илэрхийлэхийг хүсье.

С.Ганбаатар: 6 дугаар микрофон дээр Ж.Энхбаяр сайд хариулна. Дараа нь 5 дугаар микрофон дээр Б.Жавхлан сайд хариулна.

Ж.Энхбаяр: Олон жил энэ Евро-Азийн эдийн засаг холбоотой гааль тарифын хэлэлцээр хийхээр Монгол Улсын Засгийн газар ажиллаж ирсэн байдаг.

Одоо Эдийн засгийн хөгжлийн яам энэ гэрээг хариуцаад үндсэндээ нэлээн боогоод, хоёр талын тохиролцоо хоёр талаасаа нэлээн ойртоод эцэслэх түвшиндээ ирж байгаа.

Гэхдээ гэрээ байгуулагдаагүй, дуусаагүй.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны байр суурь төрийн бодлого гараад энэ хэрэгжиж байгаа 4 том багц бодлого, үүн дотроо хүнсний хувьсгалын хүрээнд эх орондоо заавал өөрсдөө тарьдаг, ургуулдаг, эцэслэн үйлдвэрлэдэг 19 нэр төрлийн бүтээгдэхүүн байгаа. Энэ бүтээгдэхүүнүүдээ бид энэ 375 нэр төрөл дээр хатуу байр суурь гаргаж хамгаална. Энэ бүтээгдэхүүнүүдийг энэ хэлэлцээрээс хасах ёстой гэсэн байр суурийг Эдийн засгийн хөгжлийн яаманд өгсөн.

Мөн холбогдох Оросын Холбооны Улсын гэрээ хэлэлцээрт орж байгаа яамдын удирдлагуудад албан захидал илгээсэн ийм байр суурьтай байгаа.

Маш их хүч хөдөлмөр гаргаж байж, асар их хөрөнгө оруулж байж бид энэ дотоодын үйлдвэрлэлийн яг нэр заасан тэр 19 нэр төрлийн бараан дээр онцгойлон ингэж босгож анхаарал тавьж ажиллаж ирсэн. Тиймд энэ энэ бодлогоо бид хамгаалах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

С.Ганбаатар: Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ хэлэлцээр одоо дөнгөж анх яригдаж байгаа асуудал ерөөсөө огт биш.

Тэгээд сүүлийн энэ чинь бүр 10 гаруй, бараг 20 жил явж байгаа ийм асуудал байгаа юм. Сүүлийн жилүүдэд Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад байгуулагдсан цагаасаа л энэ гэрээн дээр өндөр ач холбогдол өгч ингэж явж байгаа юм.

Тэгэхээр манай улсын эдийн засгийн бүтэц маань бид ер нь хэрэглэгч улс. Үйлдвэрлэгч улс руугаа явж байгаа. Бүх хүчээ ийшээгээ тавьж байгаа. Сая Ж.Энхбаяр сайд хэллээ.

Тус яамны төсвийн бодлого ерөөсөө л бид дотооддоо ядаж хүнсээ өөрсдөө бүгдийг нь 100 хувь бэлтгэдэг болохын төлөө бодлого, хүч хөдөлмөр, хөрөнгө мөнгөө, бүх юмаа ийш нь зарж явж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, гадна талаасаа импортын татвар байгаа. Тэглэхэд мэдээж сөрөг цохилт болно. Харин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам энэ дээр балансаа маш сайн судалгаа, шинжилгээ.../минут дуусав/

С.Ганбаатар: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Энэ дээр маш сайн судалгаагаа хийх хэрэгтэй.

Бид өөрсдөө үйлдвэрлэж чадаж байгаа, ойрын хугацаанд нэмж үйлдвэрлэж чаддаг болох тэр балансаа маш зөв гаргаад, гадна талаас ямар импортын цохилт орж ирэх гэж байгаа юм, үүнийгээ зөв тооцоолоод гэрээ хэлэлцээрээ үргэлжлүүлэх тийм техникийн ажил л болно.

Гэрээ эцэслэгдээгүй байгаа. Хэрвээ бид гэрээний хавсралтад тэр бараа материал дээрээ хэрвээ өөрчлөлт оруулъя, заримыг нь хасъя гэх юм бол энэ онд багтаж хийгдэх байсан олон улсын хэлэлцээр дахиад доор хаяж нэг жилээр хойшилно гэсэн үг.

Тэгэхээр нэг жилийн хугацааны асуудал уу, эсвэл ойрын хугацааны Монгол Улсын өөрсдийн үйлдвэрлэгч болох энэ баланст учирч болзошгүй эрсдэл, энэ бүх юмыг тооцоолоод хэлэлцээрээ л сайн хийх ёстой ийм л зүйл. Тийм.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Хэлэлцээрийн асуудлыг дэмжихгүй байгаа биш ээ. Хэлэлцээр хийж болно.

Гэхдээ хэлэлцээрт ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг оруулах вэ гэдгээ бид их тодорхой бодох ёстой. Монгол Улс өөрөө үйлдвэрлэгч улс орон болж байж эдийн засгийн хөгжил, эдийн засгийн өсөлт тэлнэ. Дан хэрэглэгч орон байгаад л бид олж байгаа хэдэн төгрөгийн валютаа гадагш нь урсгаад л байвал бид төгрөгийн ханшаа сулруулаад л валютынхаа ханшийг барьж чадахгүй хэмжээнд л очно гэдгийг бүгдээрээ л мэдэж байгаа.

Тэгээд энэ дээр бас нэг байр суурьтай байгаад сайд нарт баярлалаа.

Гол нь бид энэ гэрээ нэг жилээр хойшлох нь дотоодын аж ахуйн нэгжүүдээ үүд хаалгыг нь бариулахаас аль нь илүү ач холбогдолтой байх вэ гэдгээ эрэмбэлж Засгийн газрын хуралдаанаар орж ирэх асуудал дээр сайд нар маань энэ танхимд сууж байгаа, ялангуяа би 3 сайдаас, Сангийн сайд Б.Жавхлан сайд, Ж.Энхбаяр сайд, Б.Тулга сайдаас хүсэх гээд байна.

Нэгдсэн байр суурьтай байж өөрсдийн үйлдвэрлэл.../минут дуусав/

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн гүйцээж тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Энэ асуудал дээр нэгдсэн нэг байр суурьтай байж дотооддоо үйлдвэрлэж байгаа энэ гол нэр төрлийн бүтээгдэхүүн, ялангуяа үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор оруулж байгаа хөрөнгө оруулалтууд, төслүүд, зээлүүдийн ач холбогдлыг гаргаж ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Үнэхээр бид үйлдвэрлэгч орон болъё гэвэл томоохон том төслүүд ярихаас гадна жижиг, дунд үйлдвэрлэл, хүнс, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлж байж өнөөдөр Монгол Улсын эдийн засаг тэлнэ.

Түүнээс дан ганцхан уул уурхайн салбарын хоёр, гуравхан нэр төрлийн бүтээгдэхүүндээ зориулсан том төслүүд хэчнээн яваад яваад эдийн засгийн тэлэлтийг авчирч чадахгүй.

Тийм учраас энэ олон дотоодын үйлдвэрлэлийн хийж байгаа, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа энэ олон үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалж энэ асуудал дээр зарчмын байр сууриа нэгтгэж тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнийг хасаж өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Шаардлагатай бол одоо тэгээд хугацааг нь сунгах, нэг жилээр хойшлуулах асуудал нь ямар үр нөлөөтэй байх юм. Тэрийгээ судалж үзээд үйлдвэрлэгчдийнхээ эрх ашгийг нэгд тавьж өгөөсэй гэж хүсэж байна шүү.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүн санал хэллээ.

Д.Энхтуяа гишүүн асуулт асууя. Сая аудитаас асуулт асуусан. Тийм ээ. Уучлаарай. Д.Энхтуяа гишүүн дараа нь асуугаарай.

Аудит саяын асуултад хариулъя. Сангийн сайд Б.Жавхлан. 5 номерын микрофоныг нээж өгье.

Б.Жавхлан: Д.Үүрийнтуяа гишүүний асуултад нэмж хариулъя.

Би хоёр утгатай асуулт гэж ойлголоо.

Нэгдүгээрт, Төрийн өмчийн үйлдвэрийн газар өөрөө аудит хийлгэдэг байсныг яагаад Засгийн газраас шийдвэр гаргаж аудитыг нь сонгодог болсон юм бэ гэж нэг асуулаа.

Хоёр дахь асуулт нь, Үндэсний аудитын газраас хийдэг аудит давхардаж байгаа юм биш үү гэж би ингэж асуусан. Зөв үү? Тийм ээ.

Тэгвэл эхнийх дээр ийм. Ер нь яах вэ, хөндлөнгийн аудитыг Засгийн газраас сонгоод хийлгэх нь зөв юм байна. Давхар давхар хяналт гэдгээрээ. Хянуулах гэж байгаа байгууллага маань өөрөө аудит сонгох нь өмнө гарч ирсэн практикуудаас харахад учир дутагдалтай байна гэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шийдсэн учраас ийм зүйл оруулж ирсэн. Бид дэмжээд оруулсан гэсэн үг.

Тэр Үндэсний аудитын газрын. Танай хууль. Эдний хууль дээр ерөөсөө огт хөндөөгүй.

Тэгэхээр эднийх бие даасан аудитаа хийдгээрээ хийгээд явна. Засгийн газар төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээрээ хөндлөнгийн олон улсын аудитын байгууллагаар хэрхэн яаж хийлгэхээ шийдээд явдаг болъё л гэсэн давхар хяналтын л ийм л.../минут дуусав/

С.Ганбаатар: Д.Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе.

Надад гурван асуулт байна. Манай Байнгын хорооны эрхлэх яамдын хувьд.

Асуултаа яг бодит байдлаас эхэлье. Өнөөдөр бид Тавантолгой түлш гэдэг компанийн талаар ярихаас өөр аргагүй байдалтай байна. Сайжруулсан биш муужруулсан түлш хийгээд байна.

Тэгээд ард иргэд маань гадаа гудамжинд жагсаж байна.

Тэгэхээр хотын захиргаа гэхээсээ илүүтэйгээр би үүнийг Эрдэс баялгийн яамнаас асуумаар байна. Саяхан Тавантолгой түлш компани Улаанбаатар хотын мэдэлд очсон байгаа.

Гэхдээ саяхныг хүртэл “Эрдэнэс Тавантолгой” компани 51 хувийг эзэмшиж байсан, Эрчим хүчний яам 39 хувийг, Төрийн бодлого зохицуулалтын газар 10 хувийг нь эзэмшиж одоо энэ Тавантолгой түлш компани үйл ажиллагаа явуулж байсан.

Түрүүний миний хэлснээр сайжруулсан биш муужруулсан түлш болсон байгаа.

Тэгээд нийслэл хотын мэдэлд очсоноос хойш нийслэлийнх нь хийн түлшинд шилжинэ гэсэн ийм юм яриад байх юм.

Тэгэхээр энэ хийн түлшинд шилжинэ гэж юугаа яриад байгаа юм бол? Өнөөдөр манай Монгол Улсад чинь хийн түлшний асуудал яригдах хэмжээнд байгаа юм уу гэдэг ийм асуудлаас үүдээд Уул, уурхайн яаманд асуулт авъя.

Саяхан арваад жилийн өмнө энэ Тавантолгойд хийн метаны орд илрүүлж байна. Солонгостой хамтарсан хайгуул хийж байна.

Тэгээд Эрдэнэс Монгол компанийн эрхлэх ажлын хүрээнд хийн үйл чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг охин компани байгуулъя гэсэн ийм юм арваад жилийн өмнө яригдаж байсан. Үүнийг би тухайн үед нэлээн судалж байсан юм.

Тэгэхээр метаны төсөлд Засгийн газар ямар дэмжлэг үзүүлэх юм бэ? Хийн хэрэглээнд шилжинэ гээд энэ хотын захиргаа яриад байгаа дээр Засгийн газар ямар дэмжлэг гэдэг юм уу, ямар бодлого баримталж байгаа талаар эхний асуулт байна. Эсвэл одоо манайх өөрсдийнхөө энэ хийн асуудлыг орхиод, энэ Орос, Хятадын хийн хоолойг хүлээх гээд байгаа юм уу? Энэ дээр Засгийн газрын баримталж байгаа бодлого. Нэгдүгээр асуулт.

Хоёрт нь, дахиад Хөдөө аж ахуйн яамнаас асууя. Түрүүн Б.Уянга гишүүн асуугаад хариултаа сайн авч чадсангүй. Энэ бяслагийн үйлдвэрийн төсөл чинь 2021 оноос эхэлсэн юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ удаад Засгийн газрын оруулж ирсэн төсөв хамгийн шаардлагатай зүйлийгээ эхлээд оруулна. Манай “Тогтвортой хөгжлийн төлөөх зориг” гэсэн Засгийн газрын хэрэгцээтэй зүйлүүдийг оруулаад бусдыг нь танана гэсэн.

Тэгээд энэ чинь 3, 4 ширхэг юм байна шүү дээ. Бяслагийн үйлдвэр тоног төхөөрөмжийн хамт Хөвсгөл, Мөрөн, Чандмань, Өндөр-Улаан сум гээд л байна.

Ингээд 2021 оноос эхэлсэн Бяслагийн үйлдвэр төсөл Хөвсгөл Жаргалант, Цагаан-Уул, Тосонцэнгэл, Ренчинлхүмбэ, Рашаант, Их-Уул гээд л. Тэгээд дахиад л энэ “Бяслэг төсөл” гээд аягүй олон хэлбэрээр ороод ирчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ яг эн тэргүүлэх чиглэл.../минут дуусав/

С.Ганбаатар: Д.Энхтуяа гишүүнд тодруулах 1 минутыг өгье.

Д.Энхтуяа: Харин энэ дээр Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн төсөл орж ирсэн байна. Энэ дээр сайшаалтай хандаж байна.

Тэгэхээр үүнийгээ он дамнуулан 2024-2027 он гэлтгүйгээр хэрэгцээтэй төсөл рүүгээ шилжүүлээд хийчих боломж байгаа юу гэсэн асуулт байна.

Гуравт нь, Сангийн яамнаас асууя. Засгийн газрын өрийн баталгаа гаргадаг. Ингээд 14 мега төсөл дээр Засгийн газрын ямар өрийн баталгаа гаргаж байгаа вэ? Хэрвээ гаргаж байгаа бол ямар ямар төсөлд нь гаргах боломж байгаа бол?

Бид Засгийн газрын хэрэгжүүлсэн 2024-2028 оны 14 мега төслийг явуулчих юм бол Монгол Улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж би хувь гишүүний хувьд боддог юм.

Хэрвээ өнөөдрийн хэмжээнд ямар төсөлд Засгийн газрын өрийн баталгаа гаргах вэ? Одоогийн байдлаар үүргээ гүйцэтгэж чадаагүй Засгийн газрыг өрөнд оруулсан ямар ямар төслүүд байна вэ?

С.Ганбаатар: Асуултад Эрдэс баялгийн яамнаас хариулъя.

Б.Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга. 4 номерын микрофон. Дараа нь Сангийн сайд бэлтгэх байх.

Б.Жавхланбаатар: Д.Энхтуяа гишүүний асуултад хариулъя.

Тавантолгой түлш компанийн хувьд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам ямар нэг удирдлагын болон хөрөнгө оруулалтын, технологийн оролцоо байхгүй.

Тэгэхээр нийслэлээс гаргасан технологитой холбоотой нийслэлийнхэн хариулах нь зөв байх.

Харин би бол метан хийний судалгааны хувьд бас хэдэн зүйл хэлье гэж бодож байна. бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2 газар бид метан хийний судалгаа

явуулж байгаа. Нэг нь Өмнөговьд Тавантолгойн бүлэг орд дээр. Нөгөөх нь төвийн бүсэд буюу Налайх, Бөөрөлжүүт, Багануурын бүс нутаг дээр гадаадын хөрөнгө оруулалттай компани энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу судалгаа, хайгуул хийж байгаа.

Хэрэв амжилттай нөөц тогтоогдох юм бол, ялангуяа төвийн бүсэд Улаанбаатар орчимд тогтоогдох юм бол энэ метан хийг эрчим хүчинд ашиглах бүрэн бололцоотой гэдэг ийм дүгнэлттэй ажиллаж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Саяын Д.Энхтуяа гишүүн бүтээмжтэй холбогдуулж, бас үр дүнтэй холбогдуулж асууж байгаа юм шүү.

Ингээд Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Д.Энхтуяа гишүүний асуултад хариулья.

Төсөв дагасан тогтоолууд дотор 1 тэрбум доллар хүртэлх Засгийн газрын өрийн баталгааны эрх авч байгаа. Энэ бол эрх авч байгаа ерөнхий тогтоол шүү.

Яг тухайн ямар төсөлд хэдий хэмжээний баталгаа хэрэглэх вэ гэдгийг Их Хурал шийддэг. Их Хурлаар дахиж оруулж ирнэ гэсэн үг. 14 мега төслийн хувьд одоо бид яг тэр төсөл дээр Засгийн газрын баталгаа хэрэглэнэ гэж хэлэхэд эрт байна.

Бүгдээрээ яг урьдчилсан ТЭЗҮ, мөн ТЭЗҮ-ийн шат нь судалгаа нь явагдаж байгаа учраас ямар эх үүсвэрээр хийгдэх вэ, цаашаа төсвөөс хийгдэх.

Ер нь төсвөөс шууд хийгдэх төсөл бол энэ 14 мега төсөл дотор одоо байхгүй. Гаднын шууд хөрөнгө оруулалтаар, эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр, эсвэл гадаадын зээл, тусламжаар хийгдэх л ийм л бид стратегитай байгаа гэсэн үг.

Тэгэхээр тухайн үед ямар төсөл хэрэглэх вэ гэдгийг шийднэ. Их Хурал шийднэ гэсэн үг.

Хоёрдугаарт, одоогоор тухайн төсөл нь failed-чихсэн.../минут дуусав/

С.Ганбаатар: Б.Жавхлан сайдад 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Одоогоор төсөл нь фэйлдчихсэн Засгийн газрын баталгаагаа дуудуулж байгаа тийм төсөл байхгүй. Засгийн газрын баталгаа гаргасан төслүүд амжилттай явж байгаа.

С.Ганбаатар: Г.Лувсанжамц гишүүн асуулт асууя.

6 номерын микрофоныг нээгээд өгье дөө. 6 номерын микрофон дээр Ж.Энхбаяр гишүүн бас нэмэлт хариулт байгаа шүү.

Ж.Энхбаяр: Бяслалттай холбоотой Хөвсгөлийн хамт хэрэгжиж байгаа төслийг Улсын Их Хурал дээр санаачилга гаргаад Улсын Их Хурал шийдвэрлэсэн. Иймд Засгийн газар үүнийг зогсоох зохицуулалт байхгүй.

Нэгэнт эхэлсэн төслүүдээ дуусгах нь энэ Засгийн газрын зорилт байгаа. Шинэ төсөл маань цөөхөн болсон шүү дээ. 20 гаруй төсөл.

Хуучин хэрэгжиж байсныгаа 2025 ондоо бүтэн шахаад дуусъя гэсэн ийм байр суурьтай.

Хэрвээ энэ төслийг Дарханы арьс, ширний цогцолборын төсөл рүү шилжүүлнэ гэвэл энэ Их Хурлын л бүрэн эрхийн асуудал. Байнгын хорооны бодлогын асуудал. Ер нь Дарханы арьс, ширний цогцолбортой холбоотой би Байнгын хороондоо нэг бодлого, нөхцөл байдлыг нэг танилцуулга бэлдэж байгаа. Энэ төсвөө батлахаар би Та бүгдийгээ уриад нэг танилцуулъя.

Хувийн болон хувьсгалын хөрөнгө оруулалттай хоёр ийм арьс ширний цогцолборын асуудал зэрэгцчихээд эрх зүйн хувьд маргааны хувьд нэлээн олон зүйл үүсчихсэн байгаа.

Тэгээд хэрхэн шийдвэрлэх вэ гэдгээ Байнгын хороотойгоо зөвшилцөнө гэж бодож байгаа.

С.Ганбаатар: Д.Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Ж.Энхбаяр сайд та 2023 онд энэ бяслагийн төсөл эхэлсэн гээд ярьсан.

Тэгээд энэ дээр бид нарт өгсөн материал дээр 2021 онд эхэлсэн юм байна.

Тэгэхээр энэ бяслагийнхаа төсөлтэй ер нь танилцсан уу? Энэ 2021 онд эхлээд үйл ажиллагаа нь явчихсан. Жил болгон төсөв дээр мөнгө тавигдаж байна гэж би ойлгож байна.

Тийм учраас энэ амжилттай хэрэгжиж чадаж байгаа юм уу? Хөдөө орон нутагт тэр олон сумдад чинь энэ их олон бяслагийн үйлдвэр ингээд амжилттай хэрэгжиж явж болж байгаа юм болов уу? Энэ дээр эргэн харах шаардлагатай юм болов уу гэсэн ийм саналтай байна.

С.Ганбаатар: 6 дугаар номерын микрофон дээр хариулт өгье.

Ж.Энхбаяр: Энэ орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоё гээд, тэгээд улсын төсөвт дэмжлэг үзүүлээч гээд Их Хурлын гишүүн нь авч ороод тэр үйлдвэрүүдийг байгуулах, тэгээд тоног төхөөрөмж суурилуулах тэр жижиг барилгын ажлууд нь хийгдээд л яваад байгаа юм байна лээ. Ямар ч байсан нэг барилгатай болоод дуусаж байгаа ийм үзүүлэлттэй байна.

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайд хариуллаа.

Ер нь 2020-2024 онд гишүүд тойргийнхоо сонгогчдын саналыг авч бас төсөвт тусгадаг энэ практик бүх гишүүдэд байсан юм шүү. Тэдний хамгийн эмзэг, ажлын байр бий болгох ёстой, давуу талуудыг нь бас бид төсөвт тусгадаг байсан.

Ингээд Г.Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Сайн байцаана уу? Өдрийн мэнд хүргэе.

Гурван асуулт байна. Эхнийх нь Үндэсний аудитын газраас.

Танай дүгнэлтийн 6 дээр төсвийн боломжит эх үүсвэр бүх төрлийн ашигт малтмалд ногдуулсан АМНАТ-ыг бүрэн төвлөрүүлэх шаардлагатай байна гэсэн байна.

Нийтдээ хэдий хэмжээний АМНАТ бүрэн төвлөрүүлэх боломжтой, тэгээд хэд нь төвлөрөхгүй байгаа юм? Тэр талаар тодорхой мэдээлэл өгөхийг хүсэж байна.

Хоёрдугаарт нь, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хоёуланд нь хамаарах асуулт.

Сангийн яамнаас төсөв боловсруулж орж ирэхдээ 30 орчим хуудас слайд бэлдээд маш тодорхой нэг жилийн хугацаанд юу хийх гэж байгаа, хувийн хэвшлийг яаж дэмжих юм, төсөв ямар болох юм, татвар, дотаци яаж авах юм? Их тодорхой бодлогын түвшний материалуудаа танилцуулаад гишүүдэд тараадаг.

Хоёр яамнаас ээлжит бус чуулганаас хойш тийм материал нэг ч удаа авсангүй. Дандаа хүснэгт орж ирдэг. Ийм төсөл хэрэгжүүлнэ, тэдэн мөнгө төгрөг дотациар тараана гээд.

Ядаж нэг байр зүйн зураглал нь гарч ирээд бид аль бүсээ ямар хэмжээгээр хөгжүүлэх гээд цаашаа явах гэж байгаа юм. “Алсын хараа-2050”-даа хүрэхдээ бид ямар ямар алхаад хийгээд явж байгаа, 2025 ондоо энд хүрэх гэж байгаа гэсэн ийм зүйлүүдээ ингээд байр зүйн зураглал оруулаад оруулаад ядаж 5-аас 10 хуудасны слайд бэлдээд ороод ирэх хэрэгтэй байна л даа.

Төслүүдийг байршлаар нь олж харахгүй бол энэ чинь хэдэн төгрөг зарцуулж байгааг нь хараад улсын хөгжил харагдахгүй.

Хоёрдугаарт нь, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас асууя.

2025 оны төсөл дээр төсвөө танаад ороод ирж байна. Барилга байгууламж, их засвар дээр 58.6 тэрбум. Нийтдээ 17 төсөл байна. Энэ дотроос дэмжиж болохоор байгаа нь Д.Энхтуяа гишүүний сая хэлсэн Дарханы арьс, ширний цогцолборын цэвэрлэх байгууламж л байна. Бусад нь хувийн хэвшилд нь даатгаад ч юм уу, эсвэл хоршоод нь өөрсдөө хэрэгжүүлж болохоор төслүүд байгаад байна.

Цаашдаа эд нарыгаа болиод яг хувийн хэвшил дээрээ тулгуурласан Хөдөө аж ахуйн салбараа хөгжүүлнэ гэж байгаа.

Хэзээнээс ийм олон хувийн хэвшлийг хийж чадах боломжтой төслийг төсвөөс хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж явах вэ? Хэзээ болих вэ?

Дараагийнх нь, төсвийн төслийн хавсралт 1-ийн зүйл дээр шалгуур үзүүлэлт, хүрэх гэж байгаа үр дүнгээ зөв тодорхойлж гээд ээлжит бус чуулганаас хойш дандаа хэлж байгаа. Одоо гурав дахь удаагаа хэлж байна.

Хавсралт 1-ийг харахад зүгээр л сору paste байна л даа. Ээлжит бус чуулган дээр байсан. Анх өргөн барьсан төсөв дээр байсан.

Энэ яг зөв шалгуур үзүүлэлтээ хэзээнээс тодорхойлдог болох вэ?

30.1 дээр “мал аж ахуйг хөгжүүлнэ” гэж байгаа юм. Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ, малын халдварт өвчний гаралтыг бууруулна.

Эд нар ингээд тоон үзүүлэлтүүд байгаад байна. Чанарын үзүүлэлт хэзээ гарах юм бол? Аль аль аймаг, суман дээр гоц халдварт малын өвчин гарч байсан, энэ жилээс гарахаа болих ч байдаг юм уу. Тийм ээ. Тийм зорилтууд зөв байх хэрэгтэй байгаад байна.

Дараагийнх нь болохоор “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ гээд 38.1 дээр байгаа.

Зээл авсан хоршооны тоогоороо л хэмжих гээд байна л даа. Зээл аваад байвал энэ хоршоодууд хөгжөөд манай мал аж ахуйн салбар цоройгоод л тэгээд явах юм шиг харагдаад. Мөнгө өгөх нь зорилго болчихоод байгаа юм.

Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь, шинэ ажлын байр хэдээр бий болсон юм? Нийт ажлын байрны тоо, санхүүжилт авсан хоршоодын дунд бизнесийн тогтвортой байдал нь ямар байгаа юм, муу зээл байгаа юм уу, үгүй юм уу. Ийм чанарын яг чухал шалгуур үзүүлэлтээ ашиглахгүй бол бид ингээд зээл өгөөд л байх юм бол энэ чигээрээ ингээд л төсвийн үргүй зардал үргэлжлээд л яваад байхаар харагдаад байна.

Хамгийн чухал энэ хавсралт нэг гэдгийг л бид зөв зохиогоод, зөв боловсруулаад явчихдаг болмоор байна гэсэн. Хэзээ ийм болох вэ гэсэн асуулт байна.

С.Ганбаатар: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. 3 номерын микрофоныг. Аудитаас хариулна. Дараагийн асуултаудад нь бэлдэж байгаарай.

Я.Самбууням: Үндэсний аудитын газраас Я.Самбууням байна.

Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Бид 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа уул уурхайн салбарын бүтээгдэхүүнээс бий болох үр өгөөжийг бүрэн дүүрэн ашиглахад анхаарч ажиллах, тэгээд дагалдах гэж байгаа. Дагалдах ашигт малтмалд ногдох АМНАТ-ын орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлт өгсөн байгаа.

Тухайлбал, энэ дээр Татварын ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтаар Эрдэнэт төрийн өмчит улсын үйлдвэрийн газрын 2016-2018 оны татварын ногдуулалттай холбогдуулсан 33.1 тэрбум төгрөгийн авлага байгаа.

Мөн Оюу Толгой ХХКомпанийн 2013-2020 оны татварын ногдуулалт, төлөлтөд дагалдах элементтэй холбогдуулсан 62.5 тэрбум төгрөгийн татварын ногдуулалтыг авч барагдуулаач гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайд 6 дугаар микрофон.

Ж.Энхбаяр: Ажил аваад ер нь яамныхаа хөгжлийн зураглалыг хийгээд үндсэндээ дуусаж байна. Бүх мэдээллүүд үндсэндээ цэгцэрч байгаа.

Энэ төсөв батлагдсаны дараа Байнгын хорооны гишүүдийг уриад бид иж бүрэн Монгол Улсын XXI зууны хөдөө аж ахуй, түүн дээр тулгуурласан аж үйлдвэрлэлийг хэрхэн босгох вэ. Тэр зураглалтай нь, тооцоотой нь, хүний нөөцтэй нь, дэд бүтцийг нь тооцоод ингээд сайхан иж бүрэн танилцуулна.

Ажил үндсэндээ бэлэн болж байгаа. Хавсралт тэр нэг дээр хүрэх үр дүнгүүд байгаа.

Ингээд салбар салбараараа үр дүнгүүд гаргаад. Ярихаар их том сэдэв болоод багцлаад ингээд багасгасан хамгийн товч танилцуулгын хэлбэр байгаа.

Тэгээд үүнийгээ тусдаа л Байнгын хороон дээрээ нэг сайхан ярья гэж бодож байна даа.

Тэгээд дэлгэрэнгүй мэдээлэл өгнө өө. Ер нь их үр дүнгүй тун эвтэйхэн байгаа. Ялангуяа 2025 оны хүлээгдэж байгаа үр дүн бол манай хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт ер нь Монгол Улсын эдийн засагт бодитой үр дүнгүүдийг үзүүлэхээр.../минут дуусав/

С.Ганбаатар: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас саяын танилцуулга хэзээ гарах вэ гэдгийг хариулсангүй.

Хоёрдугаарт нь, энэ хүрэх гэж байгаа үр дүнгүүд бэлэн болчихсон байгаа. Болох гэж байгаа гэж ойлголоо. Тийм ээ.

Тэгэхээр энэ хавсралт 1-ийгээ хэдүүлээ дараа нь Хүнс, хөдөө аж ахуйн яам бэлэн болсных нь дараа нь яг аль зорилт, аль шалгуур үзүүлэлтүүдийг зөв болгосон гэдгийгээ бас Байнгын хороон дээрээ нягтлаад зөв тийш нь чиглүүлэх ажлыг хийгээд явъя гэдгийг Байнгын хорооны даргадаа хэлж байна.

С.Ганбаатар: Г.Лувсанжамц гишүүний асуултад тодруулж хариулъя. Их тодорхой асуулт асуусан. 4 номерын микрофон. Б.Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга.

Б.Жавхланбаатар: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд бид 14 мега төслийнхөө дарааллаар тус бүрт нь танилцуулга хийгээд явж байгаа. Эхний 3 танилцуулагдсан.

Дараагийнх нь цаг өгөхөөр танилцуулна гэж бодож байна.

Төсөвтэй холбоотой танилцуулга гэвэл төсөв дотор манайд ганцхан л хөрөнгө оруулалтын төсөл байгаа. Тэрийг жич танилцуулгыг нь өгч болно.

Ер нь хуулиараа бид Сангийн яамандаа 8 сардаа багтаад саналаа өгөөд ингээд Засгийн газарт нэгтгүүлээд л ингээд орж байгаа. Төсвийн хувьд. Тийм.

С.Ганбаатар: Г.Лувсанжамц гишүүн дахиад тодруулъя.

Г.Лувсанжамц: Б.Жавхланбаатар даргад санал байна.

Сая Ж.Энхбаяр сайд хэлж байсан. Яг энэ шалгуур үзүүлэлт бид зөв байхгүй бол аль ч салбар хөгжих боломжгүй учраас төсвөө ингээд Сангийн яаманд тайлагнах биш Байнгын хороон дээр яг саяын хэлсэн слайдаар үзүүлээд ямар шалгуур үзүүлэлтийг зөв болгоод, уул уурхайн бүтээгдэхүүнүүд хэзээ боловсруулдаг түвшиндээ очоод олон улсад өрсөлдөх хэмжээний зөвхөн түүхий эдээ гаргаад байх биш. Тийм ээ. Ялангуяа ажиллаж байгаа, хөдөлмөрлөж байгаа, уул уурхай дээр ажиллаж байгаа хүмүүсийн ажлын байрны тоо, аюулгүй байдал гэсэн иймэрхүү зүйлүүдийг ч гэсэн хэдүүлээ энэ төсөвтэйгөө цуг ярьдаг болоод батлаад явах хэрэгтэй байгаа гэсэн санал байгаа.

Тэгэхээр Ж.Энхбаяр сайдтай адилхан танай яамнаас ч гэсэн Аж үйлдвэрийн байнгын хороон дээр тийм хэмжээний бичиг баримт боловсруулж ирэхийг хүсэж байна.

С.Ганбаатар: Санал хэллээ. Буяагийн Тулга гишүүн асуулт асууна.

Б.Тулга: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье.

Ерөнхийдөө бяслагийн үйлдвэртэй холбоотой юм дээр санал хэлэх гэсэн юм. Энэ өмнөх парламент, Их Хурлаар батлагдсан, одоо үргэлжилж байгаа ийм төслүүд юм билээ.

Тэгээд энэ дээр гишүүд минь бас дэмжиж үүнийг явуулах нь зөв байх. Яагаад гэвэл үүнийг зогсоох юм бол эргээд нөгөө л мухар төмөр зам гэдэг шиг баахан хөрөнгө оруулалт хийчихсэн. Тэгээд дуусдаггүй. Тэгээд орон нутагт баахан хүлээлт үүсгэсэн ийм юм болж хөрөнгө үнэгүйдэх юм болох байх шүү.

Хөдөө аж ахуйн яамнаас асуухад яах вэ, энэ Хөвсгөл аймгийн гишүүд л их сүрхий ажилласан юм билээ. Бүх 20 суман дээрээ үйлдвэр барьж байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр 2025 онд тавигдсан төсөвт санхүүжүүлэх дүнгүүд чинь энэ төслүүдийг бүрэн дуусгаж байгаа юу?

Өөрөөр хэлбэл 2026 оны төсөв дээр дахиж энэ бяслагийн үйлдвэр яригдахгүй биз дээ гэдэг нэг тодруулж асуух зүйл байна.

Хоёрдугаарт нь, Дарханы арьс, ширний цогцолбор дээр. Энэ бол зөвхөн төрөөс оруулж санхүүжилт суучихсан байна гэж ойлгох уу? Ж.Энхбаяр дарга аа.

Урьд өмнө нь хувийн хэвшлээр хийж байсан нөгөө маргаантай байгаа гэдэг чинь энэ төсөв дээр ямар нэгэн байдлаар илэрхийлэгдэж гараагүй юу? Ганцхан сүүлд 2024 оноос эхэлсэн гэж харахаар энэ дээр юу яасан байна. Үүнийг жоохон шахаж болохгүй байсан уу? Их олон жил яригдаж байгаа ийм

төсөл байгаа. 2025 оны санхүүжилтийг нь харахад их л бага л дүнтэй л харагдаад байна л даа.

Энэ хоёр асуулт дээр.

С.Ганбаатар: Асуултад хариулъя. 6 дугаар микрофоныг нээж өгье. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бяслагийн үйлдвэр ингээд нэг дуусна.

Тэгэхээр бид нэг сайн хяналт шалгалт хийгээд эргээд Байнгын хороондоо нэг сайн мэдээлээдэхье. Үр дүн юм ямар байна.

Ер нь улс орны хөгжлийн бодлого харахад нэг аймаг нэг бүтээгдэхүүн, нэг сум нэг бүтээгдэхүүн гэдэг ийм тал руугаа их хүчтэй бодлого явж үр дүнд хүрсэн жишээ олон байдаг.

Тэгэхээр тэр талаас нь хараад бид бас ийм эерэг санаачилга юм болов уу гэж бодож байгаа. Тэгээд нэг дуусгана гэсэн байр суурьтай.

Дархан арьс, ширний цогцолбор бол дөнгөж энэ ажлыг л энэ бодлогоос салгахгүй гэсэн хэмжээнд л төсөв тавигдсан. Ер нь 100 тэрбум хүрч томоохон дэд бүтцийн ажил хийгдэх ёстой.

Тэгэхээр энэ төсөл 2025 ондоо ингээд нэг эхлэлийн хэмжээнд байна. Хамгийн гол нь Аж үйлдвэржилтийн байнгын хороо маань дахин яг энэ газар дээр нь очиж бид том танилцуулга хийгдэнэ. Том бодлогын. Тэр дээр шийдлээ гаргаад бүгдээрээ 2026 оноос яг гол фокусаа хаанаа тавих вэ гэдэг дээр шийднэ.

2 том төсөл зэрэгцээд техник, эдийн засгийн үндэслэл нь боловсрогдоод өрсөлдөөд эхэлчихсэн байгаа.

Тэгээд аль дээр нь төр оролцох вэ, аль дээр нь оролцохгүй юу. Зарим чиг үүргийг нь өөрчлөх ийм зайлшгүй шаардлагууд үүсэж байгаа. Энэ талаар би та бүхэндээ мэдээлэл өгнө.

С.Ганбаатар: Гишүүд асуулт асуулаа. Би нэг тодруулах гурван зүйл байна.

Нэгдүгээрт, ер нь Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороогоор төсөв ярьж байна. Төсвийн хоёрдугаар хэлэлцүүлэг ярьж байна. Яг аж ахуй эрхлэгч нарт, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоологч нарт, хүнд хөнгөн үйлдвэрийн энэ улсуудад бидний явж байгаа зүйлүүд ер нь хэр ойрхон очиж байна вэ, хэр мэдээлж байна вэ? Энэ заалан дотроо л бид бие биеэсээ асуулт асуугаад л бие

биедээ нэг л болчхоод л яваад байгаа юм шиг боловч яг аж ахуй эрхлэгч нарт энэ хэр очиж байгаа вэ гэдэг дээр би холбогдуулж асуулт асууя.

Нэгдүгээрт, энэ төсөв хэлэлцэх явдал, нийтийн оролцоог хангах явдал хангалттай байгаагүй. Бүгд мэдэж байгаа.

Төсвийн тухай хууль дээр 12 чухал заалт байгаа. Төсвийг олон нийтийн хэлэлцүүлэгт хамрагдуулна.

Өөрөөр хэлбэл аж ахуй эрхлэгч нарт зориулж бид төсөв баталж байгаа шүү дээ. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт, хоршоологч нарт төсөв баталж байгаа. Тэр уурхай, хүнд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн аж ахуй эрхлэгч нарт бид төсөв баталж байгаа. Хууль баталж байгаа. Энэ маань тэдэнд яг очиж байна уу? Тэдний хэлэлцүүлгийг яаж оролцуулж байгаа вэ?

Тэгэхээр миний асуулт 28¹. Төсвийн тухай хууль дээр байгаа л даа. 1.1 дээр нь төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, 28.1.2 байнгын ажиллагаатай санал авах, цахим хуудас, шуурхай утас ажиллуулах.

Ингээд 12 заалт байгаа. Би бүгдийг нь яриад яах вэ. Хэлэлцүүлгийг салбар бүрээр явуулах гэж байгаа юм шүү. Бүр салбар бүрээр явуулах. Энэ нь 28.2.2-т байгаа.

Хэлэлцүүлгээр гарсан саналуудыг бүр эрэмбэлнэ, ажиллана энэ дээр.

Тэгэхээр орж ирж байгаа энэ 2025 оны төсөв дээр яг энэ хэлэлцүүлэгтэй холбогдуулж хэдэн төгрөгийн төсөв тавьсан бэ?

Би Сангийн сайдаас асууж байна. Ж.Энхбаяр сайдаас асууж байна. Б.Жавхланбаатар Төрийн нарийн бичгийн дарга бас хариулна. Дараа нь Ц.Туваан сайд заавал ирж байх ёстой шүү. Энэ дээр. Аудит энэ дээр хамгийн гол нь хариулна.

Энэ аж ахуй эрхлэгчдийг, ард иргэдийг оролцуулахдаа та нар ирэх жил дахиад л ингээд л нэг хэдүүлхнээ дөрвөн ханан дунд суугаад л яриад байх биш ард иргэдийн оролцсон сум болгон дээр, баг болгон дээр, салбар болгон дээр хэлэлцсэн хэлэлцүүлгүүдээ бид ярих ёстой болохоос биш бид нэг их цээжээрээ ярих ёстой биш.

Энэ дээр хэдэн төгрөгийн төсөв тавив. Ирэх жил найдвартай сайхан ард иргэдийн оролцоог хангасан байна гэдэгт би итгэлтэй байна. Нэгдүгээр асуулт. Итгэлтэй байж болох уу?

Хоёрдугаар асуулт. Төсөвт маш их мөнгө тавьж байгаа. 463.3 тэрбум төгрөгийн дэмжлэг, туслалцаа, дотаци. Хоршоонд олон их наяд төгрөг байгаа.

Эрдэс баялгийн яаман дээр төрийн дэмжлэг бас байгаа. Аж ахуй эрхлэгч нарт зориулж энэ төсвийг тэдэнд ойлгомжтой ярьдаг, тэдний оролцоог хангадаг, тэднийг тендер байна уу, холбогдох зүйлүүд нь дотацид байна уу, хангалттай оролцуулахад шударга, ил тод явуулахад тэр аж ахуй эрхлэгчдийн төлөөллийн байгууллагуудыг хэр оролцуулдаг вэ? Оролцуулдаг механизм байгаа юу? Гарын авлага, зөвлөмж, сургалт, хамгийн сайн тэргүүн туршлагуудыг бас танилцуулсан тийм зүйлүүд байгаа юу?

Одоо Аж үйлдвэржилтийн байнгын хороо энэ дээр бид ёстой бүх хүчээ шавхаж ажиллана. Яаж аж ахуй нэгжүүдэд бид энэ төсөв, энэ хууль хүрэх вэ гэдэг дээр. Энэ хууль, төсөв хөл ургаад, гар ургаад өөрсдөө очихгүй.

Миний хоёрдугаар асуулт. Энэ тал дээр та нар ямар гарын авлага, ямар зөвлөмж, тэдэнтэй холбоотой, төсөвтэй холбоотой маргаан гарахад, аж ахуй эрхлэгч нартай холбоотой маргаан гарахад маргаанаа шийдүүлэх механизмууд чинь ажиллаж байгаа юу? Хуульд байгаа. Би цаг үрээд яах вэ? Тэр хуулиуд хэрэгжиж байгаа юу?

Төсөвтэй, хуультай холбоотой хэдэн маргаан яамдуудад очсон бэ? Хэдийг нь шийдсэн бэ? Миний хоёр дахь асуулт.

Гурав дахь асуулт. Найзууд аа, ер нь бид чинь аж үйлдвэрлэгчдийгээ л дэмжих ёстой шүү дээ. Засгийн газрын үндсэн ажил ажлын байр бий болгох, хүмүүсийг орлоготой байлгах. Үүнийг Засгийн газар юм уу, улс төрчид, Их Хурал шийдэхгүй. Бид зүгээр тусална. Аж ахуй эрхлэгч нар л үүнийг шийднэ.

Тэгэхээр түүнтэй холбоотой эрх зүйн орчноо бид яг хангалттай бүрдүүлж чадсан уу?

Хөнгөн үйлдвэрийн хууль хэзээ орж ирэх вэ? Одоо бол жижиг, дунд үйлдвэрлэлээс цааш гарахгүй байгаа шүү дээ. Одоо хөнгөн үйлдвэрлэл рүү оръё гэхэд эрх зүйн орчин хууль байхгүй.

Хүнд үйлдвэрийн хууль хэзээ орж ирэх вэ? Одоо энэ Эрдэс баялгийн яам энэ дээр ямар хойрго юм бэ? Энэ хууль эрх зүйн орчноо бүрдүүлээгүй байж юун мега төсөл вэ? Миний гурван асуултад хариулт өгнө үү.

5 дугаар номерын микрофон. Дараа нь 6 номерын микрофон. Дараа нь 4 номерын микрофон. Дараа нь 3 номерын микрофон.

Б.Жавхлан: С.Ганбаатар даргын асуултад хариулъя.

Ер нь олон гишүүдийн тавьж байгаа шаардлага, асуултуудад нэг зүйл их чухал зүйл явж байгаа нь гүйцэтгэлтэй холбоотой цаашдаа төсөв өөрөө санхүүжилтээ зөвхөн үүнтэйгээ байж явдаг. Хүрэх зорилго нь өөрөө маш тодорхой, хэмжих нэгж нь өөрөө тодорхой.

Тэгэхээр үүнийг тооцоолж болдог их амархан тооцоолчихдог салбарууд ч байна. Нэлээн их сайн нарийн тооцоолол хийж байж, нэлээн ахисан түвшинд ажиллагаа орох ийм салбарууд ч байгаа.

Гэсэн хэдий ч дараа дараагийн төсвөөс бид улам боловсронгуй болгох, ойлгомжтой болгох ийм шаардлагатай болж ирж байгаа.

Төсвийн реформ бол өөрөө эндээс л бид цаашаагаа үргэлжлүүлэх ёстой гэдэг дээр Засгийн газар маш сайн үүнийг цааш нь хэрэгжүүлнэ гэж хэлэх байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хэлэлцүүлгийн хувьд бид цаашдаа улам л хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хэлэлцүүлгүүдээ олон нийт рүү, ялангуяа жилийн төсвийг хүлээж авснаар дараа жилийнхээ төлөвлөлт, бизнесийн орчноо өөрсдөө үүнийгээ төлөвлөдөг, баялаг бүтээгч, хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдэд зориулж байх ёстой.

Сангийн яамны хувьд бид иргэний төсөв гэдэг ийм энгийн иргэдэд зориулсан товхимол гаргаж тараадаг байгаа. Цахим хэлбэрээр ч байгаа, цаасан хэлбэрээр ч байгаа.

Цаашдаа салбар бүхэн ч гэсэндээ өөр өөрсдийн салбарын оролцогч нартаа зориулж ийм зүйл хийдэг, хэвших шаардлагатай болж байгаа.

Төсөв гэж асуулаа. С.Ганбаатар дарга аа, яг хэлэлцүүлэгт зориулсан урсгал төсөв ч гэдэг юм уу, тийм эдийн засгийн ангиллаар шууд байхгүй. Яамд, төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөд дээрээ байгаа урсгал зардалтайгаа уялдуулж үүнийгээ бүрэн зохицуулалт хийх боломжтой.

Ер нь энэ хэлэлцүүлэг дээр тэгж их айхтар том зардал гараад байх шаардлага байдаггүй. Зохион байгуулалтаа л хэрхэн яаж хийхээс л болж байгаа юм. Цахим хэлбэрээр, биет хэлбэрээр.

Ер нь энэ жилийн хувьд яг өргөн барьснаас хойш төсөв дээр ялангуяа орон нутгийн сонгууль болсноос хойш өмнө нь байгаагүй хэмжээнд хэлэлцүүлэг хийгдсэн. Олон нийт цахим сүлжээгээрч тэр, биет хэлбэрээр ч тэр маш өргөн хүрээнд хийгдсэн гэж харж байгаа.

Тийм ч учраас одоо өнөөдөр үндсэндээ бид 5 дахь төсвөө 3 дахь сар дээрээ ингээд хэлэлцээд явж байгаа ийм зүйл байна.

Тийм учраас цаашдаа бид боловсруулалтын шатанд үүнийг маш сайн анхаарч хэлэлцүүлгүүдээ. Ялангуяа яг салбарууд буюу яамд, төсвийн ерөнхийлөн захирагч нар өөр өөрсдийнхөө чиглэлээр энэ хэлэлцүүлгүүдийг маш сайн зохион байгуулах хэрэгтэй байгаа. Зөвхөн Сангийн яаман дээрээс хэлэлцүүлэг хийгээд явчих юм маш учир дутагдалтай ийм болно.

Тийм учраас манай сайд нар хичээж ажиллана гэдэгт итгэж байна.

Маргааны талаар яамд, хууль зүйн талаар яамд хариулж байх хэрэгтэй байх. Баярлалаа.

С.Ганбаатар: 6 номерын микрофоныг нээж өгье.

Ж.Энхбаяр: Манай салбарын тухайд нийт төсвийнхөө 90 хувийг үндсэндээ баялаг бүтээж байгаа, ажлын байр бий болгож байгаа аж ахуйн нэгжүүддээ буцаан өгч байгаа.

Бодлого бүрэн эргэсэн. Сайд төвлөрүүлээд зарцуулахаас илүү аж ахуйн нэгжүүдийн тэр хөнгөлөлттэй зээлийг тэр урамшуулал ахиухан л аж ахуйн нэгжид оч гэсэн үүднээс үндсэндээ манай бодлого “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” үндэсний хөтөлбөр, “Атрын IV аян”, “Шинэ хоршоо” гэсэн 4 бодлогыг л хэрэгжүүлэх дээр бүрэн зангидагдсан.

Энэ 4 бодлого маань Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд, бүх ард түмнээр хэлэлцэгдээд, салбар салбартаа очоод ер нь маш сайн мэдээлэл, ойлголттой болчихсон. Нэлээн үр дүнгүүд нь гарч байгаа.

Энэ хөтөлбөрүүд цаашдаа үргэлжлээд явна. Үйл ажиллагаагаа мэргэжлийн холбоодтойгоо тулгуурлаж явуулж байгаа. Шийдвэрийг мэргэжлийн холбоодтойгоо хамтран гаргаж байгаа.

Сайдын дэргэдэх махны зөвлөл, ноосны зөвлөл, ноолуурын зөвлөл, арьс ширний зөвлөл, үр тарианы зөвлөл, Хөдөө аж ахуйн техникийн бодлогын зөвлөл гээд гэх мэтчилэн салбарын зөвлөлүүд.../минут дуусав/

С.Ганбаатар: Ж.Энхбаяр сайд тодруулъя.

Ж.Энхбаяр: Сайд энэ үйл ажиллагаагаа тэр мэргэжлийн холбоод, зөвлөлтэйгөө хамтраад бодлогоо гаргаж байгаа.

Ингээд бүх талын эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох, дэмжлэг үзүүлэх ажлуудыг нь зохион байгуулж байна.

Хөнгөн үйлдвэрийн хуулийг бэлэн болоод боловсруулаад боогоод дууссан.

Өмнөх Их Хурлын өмнө нь амжаагүй. Одоо ингээд өргөн барихад бэлэн. Байнгын хороотой ажиллахад үндсэндээ бүх талын судалгаа хийгдээд, хуулийн эцсийн боловсруулалт, хөнгөн үйлдвэрийн тухай хууль хийгдсэн байгаа.

Ер нь XXI зууны хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг бий болгохын тулд манай өнгөрсөн энэ хуулиудаа ер нь иж бүрэн нэг эргэж харах, хооронд нь нэг кодвикаци хийх, уялдуулах, шинэ зорилт, шинэ зохицуулалтуудаа оруулах ийм зайлшгүй шаардлага. Ялангуяа гишүүд ургамал хамгааллын агентлаг дээр их гайхаад байна. Дэлхийн хүнсний 70 хувь нь ургамлаас бүтэж байгаа.

Иймд Монгол Улс энэ олон улсын худалдаа харилцаанд ороход, мөн ургамлаар дамжиж маш их өвчин, хортон шавж, ер нь маш олон зүйл дагуулдаг учир энэ бол онцгой зүйл гэдгийг өмнөх Их Хурал хууль гаргаж, баталж, олон улсын гэрээний дагуу энэ.../минут дуусав/

С.Ганбаатар: 4 номерын микрофонд хариулт өгье. Дараа нь 3 номер.

С.Жавхланбаатар: С.Ганбаатар даргын асуултад хариулъя.

Манайх эсрэгээрээ улсын төсвийн гуравны нэгээс дээш хувийг бүрдүүлж байгаа салбар.

Та бүхэн төсвийг харах юм бол бараг манайх хамгийн бага нь байгаа байх. 48 тэрбум төгрөгийн төсөвтэй. Үүний тал нь нэг л хөрөнгө оруулалтын төсөлтэй.

Доороо 4 агентлагтай ажилладаг.

Бодлогын хувьд бид хүнд үйлдвэр, энэ уул уурхайн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүд иргэдийг мэдээж бодлогоор, эрх зүйгээр нь дэмжээд аль болох асуудлуудыг нь шийдээд явах ийм л зорилготой ажилладаг.

Хуулийн төслийн хувьд дарааллын дагуу явъя гэсэн манай сайдын барьж байгаа бодлого байгаа.

Эхлээд энэ Үйлдвэр, технологийн паркийн хууль гэж гарсан байгаа. Энэ дээр бид хэрэгжилтийг хангах, илүү.../минут дуусав/

С.Ганбаатар: 5 номерын микрофоныг нээж өгье.

Б.Жавхлан: Би нэмж хариулъя.

Ер нь төсөв дээр байгаа нэг төгрөг болгон шууд буюу шууд бус замаар эцсийн хэрэглэгч, ард иргэд дээр очдог. Цайны газар худалдан авалт болж очдог. Замдаа маш олон үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдээр дамжаад дамжаад ингээд явдаг.

Энэ 35 их наядын жишээ нь хөрөнгө оруулалт тал дээрээ бид 10 их наяд байгаа. Улсын төсвөөр, гадаадын зээл тусламжаар, орон нутгийн гээд.

Энэ 10 их наяд жишээ нь шууд аж ахуйн нэгжүүд дээр очно. Шууд үйлдвэрлэгчид дээр очно, баялаг бүтээгчид дээр очно.

Ер нь бид төсвөөр баялаг бүтээгчдийг дэмжих 3 суваг байдаг.

- ▶ *Нэгдүгээрт, хөрөнгө оруулалт.*
- ▶ *Хоёрдугаарт, урсгал зардал буюу дотациар.*
- ▶ *Гуравдугаарт, дэд бүтцээр.*

Төсөв дээр үүнээс гадуур зүйл гэж байхгүй. Бүгд энэ 3 сувгаар шууд буюу шууд бус дамжлагаар яг баялаг бүтээгч, үйлдвэрлэгч нар дээр очдог гэдгийг дахин дахин хэлье.

Дээрээс нь, энэ удаагийн төсөв.../минут дуусав/

С.Ганбаатар: Ойлголоо. 3 номерын микрофонд хариулт өгье.

Я.Самбууням: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Я.Самбууням байна. Үндэсний Аудитын газар.

Бид тухайн жилийн төсвийн төслийн хувьд төрийн аудитын байгууллагын эрх үүргийг Төсвийн тухай хуулийн 8.4.7-д 9 сарын 25-ны дотор дүгнэлтийг гаргана.

Тэгээд олон нийтэд мэдээлэх гэсэн байгаа. Бид энэ төсвийн төсөлд дүгнэлт өгөх явцдаа ард иргэдээс болон иргэний нийгмийн байгууллагуудаас ирж байгаа саналуудыг өөрсдийн “open.audit.mn” гэсэн сайтаар хүлээж авч байгаа.

Ганц энэ төсөв гэхгүйгээр бусад аудитуудын явцад ч гэсэн бид иргэдийн санал, оролцоог хангах үүдийг нээлттэй байдлаар сонсож аудитын сэдэв сонголт, аудитын үйл ажиллагаандаа ашиглаж явж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Би сая Сангийн яамныхан нэг чухал нэг зөв юм хэлсэн шүү. Юу гэвэл хэлэлцүүлгийг салбар болгон дээр олигтой явуулахгүйгээс болж Сангийн яаман дээр, дараа нь Төсвийн байнгын хороон дээр, дараа нь Их Хурал дээр төсөв хоригт ороод төсвийн үйл ажиллагаа гацаанд орж байгаа.

Салбар болгон дээр хэлэлцэх явдал, аймаг, сум болгон дээр хэлэлцэх явдал үнэхээр дутуу байгаа дээр хуулийн хэрэгжилтийг хяналт тавих гэдэг утгаараа аудитын газар энэ дээр нэг онцгой анхаарч ажиллаач ээ.

12 зүйл заалт байна шүү дээ. Энэ хэрэгжихгүй байгаа учраас л бид өнөөдөр ингээд л гишүүд хоорондоо маргалдаад л, төсөв нь амьдралд ойрхон биш байгаа. Аж ахуйн нэгжүүдэд ойрхон биш байна.

Дээр нь нэмээд хэлэхэд сая Сангийн сайд бас хариулсан. Төсөв авч байгаа хүмүүсээсээ төсвийг яаж та нарт зориулах вэ гэдэг хэлэлцүүлгээ явуулах budget төсвөө олигтой тусгаагүй байна гэдэг чинь төсөв ямар хэдэн дарга нарт зориулаагүй шүү дээ. Хэдэн сайд нар, гишүүдэд зориулаагүй. Аж ахуй эрхлэгч, иргэдээсээ асуух тал дээр салбарууд онцгой анхаарах ёстой.

Би тэгээд товчхондоо яах вэ, албан тасалгааны цонхоор амьдрал заримдаа сайхан харагддаг. Тэр төсвийг яаж аж ахуйн нэгжүүдээсээ асуух вэ, яаж тодруулах вэ гэдэг журам, гарын авлага гарсан л гээд байна.

Аж ахуй эрхлэгч нарсаасаа бид тодруулж асууна. Бичгээр Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос яамдад явуулчихсан байгаа. Энэ төсөв.

Түрүүн Б.Жавхланбаатар дарга хариуллаа. Төсвийн тухай ярилаа. Танайхаас төрийн үйлчилгээ, дэмжлэг гэж маш том юм байгаа шүү.

Ер нь энэ Засгийн газрын нэг зөв бодлого нь уул уурхайгаас орж ирж байгаа баялгаа яаж нөхөгддөг, үрждэг, хөдөө аж ахуй, мал аж ахуй руугаа оруулж байгаа гэдэг бол ерөөсөө байж болох хамгийн зөв хувилбар.

Энэ дээр ирэх долоо хоногтоо багтаад бид бичгээр явчихсан байгаа. Би протоколоор бас үүрэг өгье. Ирэх долоо хоногтоо багтаад аж ахуй эрхлэгч нарт, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоологч нарт зориулж төрийн үйлчилгээ, дэмжлэг, дотаци, төсөв, татвар. Хамгийн гол нь зах зээлийн бодлогоороо яаж дэмжлэг үзүүлэх гээд байгаа вэ гэдэг эрх зүйн орчин болон татварын талаарх бүх материал гарын авлагуудаа Аж үйлдвэрчдийн байнгын хороонд ирүүлээрэй.

Гишүүд асуулт асуулаа. Асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудлын хоёрт оръё.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Өмнөх Сангийн яамны ажлын хэсэг хэвээрээ байгаа. Би өмнө нь танилцуулсан учраас.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцье.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. /алга байна/

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алга байна/

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү?

Энэ урьдчилаад бичгээр тараагдсан байгаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу? Дагаж орж ирэх хуулийн төслүүд дээр хамт яваа юм байна шүү.

Санал алга байна. /алга байна/

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. 3 дугаар зүйлтэй холбогдуулж.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алга байна/

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү?

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу?

Д.Үүрийнтуяа гишүүний санал ирсэн байна. Ингээд бид танилцуулъя. Д.Үүрийнтуяа гишүүн саналаа өөрөө тайлбарлах байх. Тийм ээ.

Би саналыг танилцуулъя. Д.Үүрийнтуяа гишүүн тайлбараа өгнө.

Саналын томъёолол. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд байгаа. Уг хуулийн төслийн 4 дүгээр зүйл.

Энэ “хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө” гэсэн заалтыг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж даган мөрдөнө” гэж өөрчлөх гэсэн ийм саналтай байна.

Саналаа Д.Үүрийнтуяа гишүүн тайлбарлана.

Д.Үүрийнтуяа: Төсвийн тухай хуулийг дагаж орж ирж байгаа хуулийн өөрчлөлтүүдийн хэрэгжиж эхлэх хугацаа бүгдээрээ энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм зохицуулалттай яваад байгаа.

Тэгээд 2025 оны төсвийн хуулийг дагаж орж ирж байгаа өөрчлөлт бол тухайн төсвийн жил эхлэх хугацаанаасаа дагаж мөрдөх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Одоо 12 сарын 15-ны дотор магадгүй Улсын Их Хурал энэ хуулийг баталлаа гэхэд 2024 оны 12 сарын сүүлийн хагас сарын асуудалд энэ хуулийн хэрэгжилтийг мөрдөх асуудлыг хууль хяналтын байгууллага шалгахдаа шаардаж эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр энэ амьдралд хэрэгжихэд бас нэлээн асуудлууд үүсгэнэ.

Дараа нь нэг баахан санхүүгийн зөрчил үүсэх асуудлууд гарах эрсдэлтэй байгаа учраас тухайн төсвийн жилээ дагаж явах нь зүйтэй гэж үзэж байгаа.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүний саналын томъёололыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

58.8 хувиар дэмжигдлээ.

Дамбын Батлут гишүүн дэмжсэн гэдгийг протоколд тусгая.

Д.Үүрийнтуяа гишүүний санал дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Дээрх тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах Улсын Их Хурлын гишүүд байхгүй учраас санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир гишүүн Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хэлэлцэх асуудал гурав.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан саналын дагуу, Д.Энхтүвшин гишүүн бас санал гаргасан шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар “Эрдэнэс Тавантолгой” компанийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийн удирдамжийг Та бүхэнд танилцуулъя.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан “Эрдэнэс Тавантолгой” компанийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэх.

Мөн тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанд танилцуулахыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч С.Ганбаатарт үүрэг болгосугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм ажлын хэсгийн тогтоол байгаа. Тогтоолоо танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд байвал саналаа өгнө үү.

П.Мөнхтулга гишүүнээр тасаллаа. Буяагийн Тулга гишүүн асуулт асууя.

Б.Тулга: Өдрийн мэнд хүргэе. Та бүхэнд.

Ажлын хэсгийн удирдамжийн 4 дүгээр гүйцэтгэх ажил дээр санал байна дарга аа.

“Эрдэнэс Тавантолгой” компанитай гэрээ байгуулан хувийн хөрөнгө оруулалтаар ажиллаж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн талаар үнэлэлт газар дээр нь өгч танилцах гэж нэмж оруулмаар байна.

Зөвхөн төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийчихсэн юмнууд бас байх шиг байна лээ.

Тэгэхээр энэ дээр бас хэдүүлээ газар дээр нь очиж үзэх ёстой байх.

Хоёрдугаарт нь, 2 дахь заалтаар нь “Эрдэнэс Тавантолгой” компанийн лицензийн эзэмшилтэй холбоотой юм дээр бас нэг үнэлэлт дүгнэлт өгмөөр байна.

Тэгэхгүй бол янз янзын байдлаар нөгөө нийгэмд буруу зөрүү яригдаад байдаг тэр лицензийг, энэ лицензийг ийм нэр бүхий хүмүүсээс авсан, аваагүй гэдэг асуудлууд байдаг юм билээ.

Үнэхээр авсан бол авсан гэдгийг нь хэдүүлээ ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд гаргах нь зөв байх. Хэрвээ ямар нэгэн байдлаар аваагүй, тэр компани дээр байж байгаа бол үүнийг тодорхой болгох нь зөв байх гэсэн ийм хоёр саналтай байна.

С.Ганбаатар: Б.Тулга гишүүн маш ажил хэрэгч чухал санал хэллээ. Хоёр санал байна. Би шууд хариулаад явах ёстой байх. Асуултад.

Зарим гишүүд бас тодруулж байгаа.

Ер нь удирдамж батлах батлах тогтоол дээрээ нэлээн дэлгэрэнгүй тавих боломж байна уу. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа гэсэн байна гэж байгаа.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэх асуудлуудаа хуваарилчихсан байдаг учраас энэ асуудал яг хуулийн хүрээнд бид үйлдвэржилттэй холбоотой энэ тогтоолоо баталж байгаа боловч удирдамж дээрээ энэ үйлдвэржилттэй холбогдуулж бусад асуудлуудаа удирдамж дээрээ чөлөөтэй оруулж өгч байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Тэгээд Б.Тулга гишүүний энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай холбоотой олон маргаантай асуудлууд байгаа. Яг тэр үнэн шүү.

Тэгээд Эрдэнэс Тавантолгойн лицензийн эзэмшилтэй холбогдуулсан бас гомдол маргаан явдаг. Үүнийгээ энэ аж үйлдвэржилттэй холбогдуулж бид энэ удирдамждаа оруулж шалгах болно. Үүнийг бас оруулна.

Б.Тулга гишүүний саналд би хариулт өглөө. Оруулах ёстой. Үүнийг протоколоор авна.

П.Мөнхтулга гишүүн асуулт асууна.

П.Мөнхтулга: Би энэ хам хүрээн дээр нь гайхаад байсан юм л даа. Ажлын хэсэг нэгэнт шалгаж байгаа бол. Тэгээд бас нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй байгуулагдчихсан юм байна.

Яагаад зөвхөн баяжуулах үйлдвэрээр хам хүрээгээ тогтоож байгаа юм уу гэж асууж байсан юм.

Тэгээд түрүүн Б.Тулга гишүүн бараг миний асуултыг асуучихлаа. Тэр бас нэг эзэмшлийн асуудал гээд л Б.Энхбаяр сайд бас нэг баахан юм яриад л яваад байгаа шүү дээ.

Тэгээд үүнийг нэгмөсөн хагалаад өгчихвөл. Энэ үнэн ч юм шиг, худлаа ч юм шиг юм л яваад байгаа шүү дээ.

Тэгээд хэзээ ч шийдэгдэхгүй. Ард түмний хүлээлт бас байгаа. Сонгуулиас өмнө нүүрсний 44 наядын хулгайч билүү. Ингээд баахан хулгай яриад байдаг. Тэр нь илэрдэггүй. Юу болоод байгаа нь мэдэгдэхгүй. Ард түмэн хүлээгээд байдаг.

Тэгээд энэ болгоны ард нь ажлын хэсэг ажиллаад үнэн мөнийг нь гаргаж ирэх ёстой болов уу л гэж бодоод байна. Тийм болохоор хам хүрээгээ жоохон тэлбэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа.

С.Ганбаатар: Саналыг хүлээж авъя.

Энэ дээр харин нөгөө саналын томъёолол дээр бас П.Мөнхтулга гишүүн ээ, ярилцана шүү. Б.Тулгаа гишүүн ээ, саналын томъёололыг бид бас ярьж байгаад томъёолчихдог. Бас зарим нэг юмыг нь дутуу орхичихгүйн тулд хамтдаа боловсруулъя.

Тэгээд саналыг авлаа. Тэгье. Бичгээр саналаа өгчихвөл бүр сайн байна.

Ингээд 2 гишүүний саналыг авсан. Хүлээж авлаа.

Тогтоолын төслийг баталъя гэсэн саналыг хураая. /алх цохив/

Гишүүд түр хүлээж байгаарай. Энэ ганцхан асуудал байгаа шүү.

58.8 хувиар санал дэмжигдлээ. Д.Батлут гишүүн дэмжсэн гэдгийг бас оруулъя.

Түрүүн тэр төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиуд дотроос нэг хууль бас хаягдсан байна шүү. Та бүхэн маань тэр дээр саналаа өгнө үү.

2025 оны төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Энэ та бүхэнтэй хавсралтаар хамтдаа бүгдээрээ оччихсон байгаа зүйлүүд шүү.

Үүнтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу?

П.Мөнхтулга гишүүний саналыг сонсьё.

П.Мөнхтулга: Уг нь асуулт байсан. Саналтай хамт нэгтгэчихье.

Засгийн газарт чиглэл өгөх дээр манай Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн 14 төсөл байгаа.

Тэгээд Засгийн газрын мөрийн хөтөлбөр удирдах хэсэг дээр нь “эдийн засгийг солонгоруулна” гэхсэн байгаа юм.

Тэгээд одоо энэ төсөв дээр өргөн барьсан байдлыг харахаар, тэгээд энэ 14 мега төслийг харахаар солонгорсон юм нэг ч байхгүй. Нөгөө л уул уурхайн төслүүд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид чинь Аж үйлдвэрийн байнгын хороо.

Тэгээд энэ Байнгын хорооноос бид Засгийн газарт үүнийг Хөдөө аж ахуйн чиглэл рүү. Бид чинь нийт хүн амын маань хөдөлмөрийн зах зээл чинь 1 сая 200 мянган хүнтэй бол тэрний 21 хувь нь 300 мянга гаруй хүн нь хөдөө аж ахуйн салбар дээр ажилладаг байхгүй юу.

Тэгээд хөдөлмөрийн зах зээлийн 21 хувь нь Хөдөө аж ахуйн салбар дээр ажиллачхаад дотоодын нийт бүтээгдэхүүний 10-хан хувийг бий болгодог.

Тэгэхээр энэ хөдөлмөрийн зах зээлийн иргэдийн ерөөсөө хөдөлмөрлөөд үр шим нь гарахгүй байна л гэсэн статистик тоо.

Тэгэхээр энэ дээр бид Засгийн газарт чиглэл өгөх гэж байгаа бол нэгд өөрийнх нь мөрийн хөтөлбөр дээр ч байгаа, тэргүүлэх чиглэл дээр нь ч байгаа. Хөдөө аж ахуйн ядаж нэг төсөл оруулж ир гэж үүрэг чиглэл өгмөөр юм билээ.

С.Ганбаатар: П.Мөнхтулга гишүүн чухал ажил хэрэгч санал гаргалаа. Энэ саналыг санал, дүгнэлтдээ тусгаад, тэгээд Төсвийн байнгын хороонд өгье. Үүнийг гишүүний нэрийг бүр дурдаж санал, дүгнэлтдээ тусгаад үүнийг өгье гэдэг ийм санал байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Санал байна уу? Д.Үүрийнтуяа гишүүн хоцорчихлоо. Д.Үүрийнтуяа гишүүн саналаа. Манай Д.Бум-Очир гишүүн та өгөх учраас саналуудыг тусгаж хэлж өгөх юм байна шүү. Төсвийн байнгын хороонд.

Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Тогтоолын төслийн 5-ын “а”-д заасан байгаа. 10 хувь бууруулах зардлын асуудлыг.

Тэгээд боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдан авах зардал гэж байгаа юм.

Тэгээд дээр нь нэмээд энэ мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн суралцагчдад олгож байгаа тэтгэлэг, төрийн өмчийн их дээд сургуулиудын тогтмол зардал.

Тогтмол зардал ч яах вэ эндээ ордог юм байгаа биз. Бид хүүхдүүдийнхээ хоолны мөнгийг 10 хувиар хасчхаж болохгүй л дээ. Өнөөдөр хүрч ядаж байгаа.

Өнөөдөр нэг дотуур байрны хүүхэд өдөрт энэ чинь 5 мянга хүрэхгүй төгрөгөөр хооллож байгаа шүү дээ. 4300 төгрөгөөр. Том ангийн хүүхэд нь 4900 төгрөгөөр.

Тэгээд энэ чинь худалдаж авах зардал уу. Тэр чинь өдрийн 3 хоол, 2 унд шүү дээ. Тэгээд тэрийгээ дахиад 10 хувиар бууруулна гэхээр чинь энэ чинь юу болж хувирах юм бэ.

Тэгэхээр яг энэ хүүхэдтэй холбоотой хэсгийг хасмаар байна.

С.Ганбаатар: Д.Үүрийнтуяа гишүүний ажил хэрэгч санал байна. Үүнийг ажлын хэсгийнхэн анхааралдаа авна биз. Авах ёстой шүү.

Тэгээд манайх яах вэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд гэж байгаа боловч энэ асуудлыг тэр холбогдох ажлын хэсэгт нь бас санал гаргаж тусгана гэдэгт би итгэлтэй байна.

Д.Бум-Очир гишүүн саналаа хэлье. Засгийн газарт чиглэл өгөх тухай. Д.Бум-Очир гишүүний микрофоныг нээж өгье.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

П.Мөнхтулга гишүүний санал маш чухал санал хэлчихлээ. Бид олон жил солонгоруулах тухай асуудал ярьж байгаа. Өнөөдөр бид уул уурхайн олон орон болоод яваад байгаа.

Тэгээд энэ тодорхой хэмжээгээр гацаа авчирдаг. Бид уул уурхайгаасаа ашиг олчихно гээд бусад салбараа тодорхой хэмжээгээр анхаарахгүй юм уу, орхигдуулах ийм зүйл зөвхөн энэ жил биш өнгөрсөн жилүүдэд хавтгай явж байгаа. Хөдөө аж ахуйн салбараа дэмжье гэдэг энэ зүйл.

Нөгөө олон сая малынхаа бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулъя.

Тэгэхээр энэ чиглэлээр дорвитой ажлуудыг бас тусгаж өгье өө. Ядаж нэг төсөл тусгаад ороод ирээч ээ гэдэг бол дэмжиж байгааг хэлмээр байна. Ер нь цааш цаашдаа энэ салбараа дэмжмээр байгаа юм. Ер нь Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбаруудыг. Зөвхөн малчдыг дэмжих биш. Одоо ингээд ярихаар “Шинэ хоршоо”-гоо л ярьчих байх л даа.

Тэр бол тусдаа нэг хэрэг. Энэ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг бид, ялангуяа манай Байнгын хороо онцгой дэмжиж шахаж ажиллах хэрэгтэй байна гэдгийг нэмж хэлэх гэсэн юм.

Сая тэр хүүхдийн хоолны тухай асуудал. Би Боловсролын байнгын хороон дээр байгаа. Маргааш хуралдах байх. Тэр хороон дээрээ энэ тухай саналаа бас ярья гэж бодож байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Д.Бум-Очир гишүүн чухал саналууд хэллээ.

Тэр хөдөө аж ахуйтай холбоотой, мал аж ахуйтай холбоотой, боловсруулах үйлдвэрлэлтэй холбоотой чухал саналыг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Цөмөөрөө Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо чуулган дээр энэ асуудлыг хамгаалж дуу хоолойгоо оролцох болно. Манай гишүүд тэгнэ гэж бодож байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг саяын холбогдох 3 гишүүний саналыг тусгаад Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Хүргүүлэхээр болж байна.

Ингээд хэлэлцэх асуудлыг дууссаныг мэдэгдье.

Ирэх долоо хоногт Үйлдвэр, технологийн паркийн асуудал орж ирнэ гэдэг мэдээллийн чанартай зүйл хэлье. Баярлалаа.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 11 цаг 32 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД